

Монгол, манж хэлний үндсэн тооны нэрийн тухайд

Э. Мөнх-Учрал*

- I. Нэгээс арав хүртэлх тооны нэр
- II. Арваас хорь хүртэлх тооны нэр
- III. Хориос дээших тооны нэр

Үндсэн тооны нэрс нь хэлнүүдийн гарал болон харилцан нөлөөллийн байдлыг тодруулах үүднээс зайлшгүй анхааран судлууштай үгс бөгөөд харьцуулсан хэлшинжлэл төдийгүй угсаа, сэтгэц хэлшинжлэл, соёлын харилцааны түүхийн чухал судлагдахуун билээ. Тиймээс ч төрөл хэл, аялгууны салсан он цагийг тогтоох арга зүйг боловсруулахад шалгуур болгосон сонгомол үгсийн тоонд үндсэн тооны нэрсийг оруулсан байдаг.¹ Нэгэн цагт нэгдмэл цогц байгаад салбарлан салсан гэж үздэг, ахуй амьдралын хэв шинж, хэл бичиг, сэтгэлгээгээр ойр дөхүү, түүх соёлын өнө удаан жилийн харилцаатай байсан монгол, манж хэлтний үндсэн тооны нэрийг хэлшинжлэлийн үүднээс харьцуулан үзэхэд олон сонирхолтой асуудал урган гардаг бөгөөд энэхүү өгүүлэлд манж, монгол хэлний үндсэн тооны нэрийн бүтцийн талаар санал нэмэрлэхийг зорилоо.

I. Нэгээс арав хүртэлх тооны нэр
Mo. *nigen* – Ma. *emu*

- | | | | |
|---------------------------|--------------|----------------------------|-----------------|
| 1. Монгол бичгийн хэл | <i>nigen</i> | 2. Дагуур хэл ² | <i>neke</i> |
| 3. Зүүн ёгор ³ | <i>nege</i> | 4. Могол ⁴ | <i>nika~ika</i> |

* Монгол Улсын Их Сургууль, Монгол хэл, Соёлын Сургууль

¹ Широ Хаттори, *Монгол хэлнүүдийн салсан оныг судлах нь*, Хэл зохиол, 4-р боть, 1-4 –р дэвтэр, Улаанбаатар, 1967, 170-174 –р тал.

² Samuel E. Martin, *Dagur Mongolian Grammar, Texts, and Lexicon*, Indiana University, Bloomington, 1963, pp.32-35, Н. Н. Поппе, *Дагурское наречие*, Ленинград, 1930, стр. 147; Б. Х. Тодоева, *Дагурский язык*, Российская Академия Наук, *Языки Мира*, Москва, 1997, стр. 56.

³ Зүүн ёгор хэлний тооны нэрсэд дараах бүтээлийг эш болгов: Б. Х. Тодоева, *Шира югуров язык*, Российская Академия Наук, *Языки Мира*, Москва, 1997, стр. 150.

⁴ Могол хэлний тооны нэрсэд дараах бүтээлийг эш болгов: Е. А. Кузьменков, *Могольский язык*, Российская Академия Наук, *Языки Мира*, Москва, 1997, стр. 94.

5. Баоань ⁵	нэгэ	20. Ороч	ом ~ омо ~ ум ~ эму
6. Монгор ⁶	нигэ	21. Уд	омо
7. Дунсян ⁷	ниэ	22. Ульч	омо(н)~ ум(н)
8. Халимаг ⁸	негн	23. Орок	умүкэ
9. Дөрвөлжин бичиг ⁹	ᠨᠢᠭᠡᠨ nigen	24. Нанай	эмү
10. Монгол и и юй	亦下 igen (nigen) ¹⁰	25. Турк ¹¹	bir
11. Хуа и и юй ¹²	你刊 niken	26. Чуваш ¹³	rër(ё)
12. Араб үсгээрх монгол дурсгал ¹⁴	nigen	27. Азарбайжан	bir
13. Халимаг ¹⁵	нээгн	28. Татар	бер
14. Манж	emu	29. Казак	бир
15. Зөрчин ¹⁶	— (эму)	30. Тофалар	bir'e
16. Хамниган эвенк ¹⁷	ömün, эмүн, умүн	31. Тува	бирээ
17. Эвен ¹⁸	омьн	32. Хакас	пирöлен
18. Солон	эмү	33. Башкир	берэу
19. Негидал	өмөн	34. Киргиз	бире

Дээрх харьцууллаас “1”-ийн тооны нэр нь:

монгол төрлийн хэлэнд:

“*ni-ne*” язгуур + “*gen-ken, gn, ge-ke-ka, k*” бүтээвэр,

манж-түнгүс хэлнүүдэд:

“*e, o-ø, y-y*” язгуур + “*min-mün, mön-mon, mi-mü, m*” бүтээвэр

гэсэн бүтэцтэй байна.

⁵ Баоань хэлний тооны нэрсэд дараах бүтээлийг эш болгов: Б. Х. Тодоева, *Баоаньский язык*, Москва, 1964, стр. 60-61; Б. Х. Тодоева, *Баоаньский язык*, Российская Академия Наук, *Языки Мира*, Москва, 1997, стр. 34.

⁶ Монгор хэлний тооны нэрсэд дараах бүтээлийг эш болгов: Б. Х. Тодоева, *Монгорский язык*, Российская Академия Наук, *Языки Мира*, Москва, 1997, стр. 129; *Баоаньский язык*, Москва, 1964, стр. 60-61.

⁷ Дунсян хэлний тооны нэрсэд дараах бүтээлийг эш болгов: Б. Х. Тодоева, *Дунсянский язык*, Российская Академия Наук, *Языки Мира*, Москва, 1997, стр. 64; Б. Х. Тодоева, *Баоаньский язык*, Москва, 1964, стр. 60-61.

⁸ Халимаг хэлний тооны нэрсэд дараах бүтээлийг эш болгов: *Калмыцко-Русский словарь*, под редакцией Б. Д. Муниева, Москва, 1977., Э. Р. Тенишев, *Иссык-кульских калмыков язык*, Российская Академия Наук, *Языки Мира*, Москва, 1997.

⁹ Дөрвөлжин бичгээр тэмдэглэгдсэн тооны нэрсийн галигт дараах бүтээлийг эш болгов: Н. Н. Поппе, *Квадратная письменность*, Москва, Ленинград, 1941.

¹⁰ Энд “igen” хэмээсэн нь ташаа, зүй нь “niken” буюу 你 “ni” байх ёстойг Ö. Manduqu, *Mongyol i iui toli bičig*, 1995, 133-р талаас лавлан үзнэ үү.

¹¹ Түрэг төрлийн хэлний жишээг Л. Болд, *Түрэг, монгол хэлний тооны нэр*, Улаанбаатар, 2005 –аас эшлэв.

¹² Ö. Manduqu, *Mongyol i iui toli bičig*, 1995, 133-р талаас лавлан үзнэ үү.

¹³ Чуваш хэлний жишээнд дараах бүтээлийг эш болгов: András Róna-Tas, *Nutshell Chuvash*, Szeged, Hungary.

¹⁴ Д. Төмөртоогоо, *Араб үсгийн монгол дурасгалын судалгаа*, Улаанбаатар, 2002.

¹⁵ Э. Р. Тенишев, *Иссык-кульских калмыков язык*, Российская Академия Наук, *Языки Мира*, Москва, 1997, стр. 71.


¹⁶ Зөрчин хэлний тооны нэрсийн ханз болон ханзны дуудлагад дараах бүтээлийг эш болгов: 金啓琮, *女真文辞典*, 北京, 1984.

¹⁷ Хамниган, эвенк хэлний тооны нэрсэд дараах бүтээлийг эш болгов: Б. Ринчен, *Монгол ард улсын хамниган аялгуу*, Улаанбаатар, 1969. Мөн Toshiro Tsumagari, *A Basic Vocabulary of Khamnigan and Oluguya Ewenki*, Bulletin of the Institute for the Study of North Eurasian Cultures, 21, 1992, pp.83-103, *Сравнительный словарь Тунгусо-манчжурских языков*, Отв. редактор В. И. Цинциус, Ленинград, 1975.

¹⁸ Манж-түнгүсийн төрөл хэлнүүд болох эвен, солон, негидал, ороч, уд, ульч, орок, нанай хэлний жишээг *Сравнительный словарь Тунгусо-манчжурских языков*, Отв. редактор В. И. Цинциус, Ленинград, 1975-аас эшлэв.

Бид монгол, манж хэлний “нэг” гэсэн тооны нэрийг гарал нэгтэй, “*ni-/ne-* язгуур + *yan-gen* / *mun~mün* бүтээвэр” гэсэн бүтэцтэй бөгөөд нэн эртний хэлбэр нь “b ~ m ~ g” гийгүүлэгч сэлгэдэг авиан зүйн түгээмэл зүй тогтлын дагуу ‘*niben*’ байсан болов уу хэмээн үзэж байна. Тэгвэл монгол хэлний “*nigen*”, манж хэлний “*etu*” хоёрын язгуур гарлын хувьд хэрхэн холбогдох вэ? гэдэг асуулт гарч ирнэ.

Монгол хэлнээ **ni* язгуур нь **ni-*, **ne-* гэсэн хувилбартай. Алтай хэлнүүдийн тооны нэрийг харьцуулсан судалсан эрдэмтэн Г. И. Рамстедт уг тооны нэрийн эртний язгуурыг **ni-*, **nei-* гэсэн бүтэцтэй гэж үзсэн байдаг.¹⁹ **nei* гэдэг нь “*ne*” язгуур болон үйл үг бүтээх “-*yi*” [<**gi*] бүтээвэр гэсэн нийлмэл бүтэц юм. Ийн бүтсэн *neyite* [<**ne-gi-te*], *neyile-* [<**ne-gi-le*], *neyid-* [<**ne-gid-*] гэх мэт олон үг бий.

“Манжийн дусал бинтгүй үсгийн бичиг”²⁰ -г ‘*etu*’-г ‘*netu*’ гэж бичсэн байдаг тухай Л. Мишиг гуай дурдсан байдаг.²¹ Мөн “Хуучин манж бичгийн данс”²² -д ‘*netu*’ () гэж бичсэн газар цөөнгүй бий. Мөн ‘*ni-*’ язгуур нь манж хэлний нийлэх, түших гэсэн утгатай “*nikere*” гэсэн үгэнд бий. ‘*ni*’ язгуур ямар утгатай вэ? Мэдээжийн хэрэг нэг цул юм гэсэн ерөнхий утгатай. Энэ тухайд М. Базаррагчаа “Монголчууд нэгдэж нийлэхийг нэг цул гэж ухаардаг байв. Тиймээс ‘*ni*’ нь нийлэх утгатай юм”,²³ С. Дулам “*ни-*” язгууртай үгсийг дурдаад “... гэх мэтийн үгс нь бүхэл, цул, үл хуваагдах гэсэн шиг утгатай” ... “нуух, нууц, нуур, няг” зэрэг үгсийг энэхүү “*ни-*” язгуураас гаралтай²⁴ гэж, Сон Йиминь ‘*nigen*’ хэмээх тооны нэр нь угтаа ‘*narap*’ /нар/-ы утгатай бөгөөд ‘*niyica*’ /нууц/ гэсэн үг энэ ‘*ni*’ язгуураас үүсчээ”²⁵ , Д. Чойжалсүрэн өмнө, хойно гэсэн үгийн гарлыг тайлбарлахдаа, ‘*etun-e*’-ийн ‘*etu*’ язгуур нь нэгийн, ‘*qoyin-a*’-ийн ‘*qoi*’ язгуур нь хоёрын утгатай хэмээн Г. И. Рамстедтийн саналыг дэмжжээ.²⁶

Бүтээврийн тухайд, эвен, эвенк, негидал, ульч зэрэг түнгүсийн хэлний баримтаас үзвэл, манж хэлний ‘*etu*’ нь эцэстээ ‘*n*’-тэй байгаад гээгдсэн нь илэрхий. Зарим төрөл хэлэнд *gen~min* [<**ben*] бүтээврийн бүтцээс “*n*” гийгүүлэгч нь сугарсан, эгшиг нь давшин ижилшсэн, балархайшсан байдал буй авч бүтээврийн хэлбэрүүд төрөл хэл дотроо үндсэндээ харилцан

¹⁹ G. J. Ramstedt, Über die Zahlwörter der Altaischen Sprachen, JSFOu, 24:1, 1907, S.4;

²⁰ Манжийн Нурхачи баатар 1599 онд зарлиг болсноор манж нар монгол үсгээр манж хэлээр бичих болсон бөгөөд бичгийн хэлнийхээ хөгжлийн дараагийн үе шатанд монгол бичгийн үсгийн махбодод дусал бинт нэмж, манж бичгийг боловсруулжээ. Хожим 1741 онд дусал бинтгүй үсэг манж бичгийн үндэс гэдгийг сануулах зорилгоор Тэнгэрийн тэтгэсэн хаан зарлиг буулгаж, сайд Ортай, Сүй юань мэн нар “Дусал бинтгүй үсгийн бичиг” хэмээх толь зохиосон нь XVII эхэн үеийн манж хэл аялгууны чухаг дурсгал болон үлдсэн юм.

²¹ Л. Мишиг, Манжийн дусал бинтгүй үсгийн бичгийн тухай, Монгол Улсын Их Сургууль, Эрдэм шинжилгээний бичиг, Улаанбаатар, 1964.

²² Манж нар, XVII зууны эхэн үед (судлаачдын бичсэнээр 1607-1632 онд) хамаарах албан баримтыг хожим эмхлэн гар бичмэлээр товхисон нь манжаар “*Ejehe dangse*” (орчуулбал, *Ойлого данс*) нэртэй бөгөөд эдүгээ Тайванийн хааны ордны музейд хадгалагдаж буй. Уг дансыг Тэнгэрийн тэтгэсэн хааны зарлигаар сийрүүлэхдээ “*Tongki fuqa aqū hergen i dangse*” (орчуулбал, *Дусал бинтгүй үсгийн данс*) хэмээн нэрлэсэн ба хятадаар 舊滿洲當 (jiu man zhou dang, орчуулбал, *Хуучин манж данс*) хэмээн нэрлэж хэвшжээ.

²³ М. Базаррагчаа, Монгол үгийн гарлыг мөшгих нь, I, Улаанбаатар, 1992, 173-181 -р тал.

²⁴ С. Дулам, Монгол бэлгэдэл зүй I, Тооны бэлгэдэл зүй, Улаанбаатар, 2007, 24-р тал.

²⁵ Сон Йиминь, Монгол хэлний нууц ‘*niyica*’ хэмээх үгийн уугал утга, Монгол Солонгосын хамтарсан эрдэм шинжилгээний бичиг, Улаанбаатар, 2000.

²⁶ Г. И. Рамстедт, Введение в Алтайские языкознание, Морфология, Москва, 1957, стр. 165.

тохирч байгаа нь харагдаж байна. Академич Д. Төмөртоогоо монгол хэлний нэгийн тооны нэрийг бүтээврээр нь “*ni-ke-n*” гэж задлаад, “*ke*”-г тооны нэрийн үндэс бүтээх бүтээвр, “*n*”-ийг тооны нэр бүтээх бүтээврийн дараа орж, тухайн тооны нэрийн хамжих үндэс үүсгэх үүрэгтэйгээр хэрэглэгддэг, “... бүтэц, үүргийнхээ хувьд биеэ даасан морфемын шинжитэй гэж үзэж болмоор санагдана. Уул морфемын тохиолдох байр, гүйцэтгэх үүрэг нь аль ч тооны нэрд адил...” гэжээ.²⁷ Монгол хэлний тооны нэрийн бүтцийг судалсан эрдэмтэд бүтээврийг нь “*-ken/-gen*” гэж хам байдлаар үзсэн байдаг бөгөөд бид ч мөн адил, тооны нэр нь “*язгуур+ ʎan/ban дагавар болон түүний хувилбарууд*” гэсэн бүтэцтэй хэмээн үзэж байна. Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалуудад уг тооны нэр үндсэндээ “*n*” агуулсан хэлбэрээр 226 удаа тохиолдож байхад “*n*”-гүй хэлбэр ердөө 3 удаа таарна.²⁷ Дэс тооны нэр үүсгэх бүтээвр авахдаа ч үндсийнхээ “*n*”-ийг хадгалсан байдал “*Хуа и и юй толь*”-д “*qorindu'uar hon* (хориндугаар он)”, “*qorin nikentü'er hon*” (хорин нэгэндүгээр он) зэргээр буй аж.²⁸

‘*nigen*’, ‘*emu*’ хоёртой гарал нэгтэй доорх үгс байна.

Монгол хэлэнд:

ni- nige, nigen, nigemüsün, nigebüri, nigedüger, nigente, nigeče, nigeči, nigečile-, niged-, nigedümel, nigedümelji-, nigedül, nigedülčin, nigedülji-, nigedke-, nigedkel, nigeten, nijiged [<*ni-de-ged], nigeken, nigemüsün, nigedeki, nidkel, nidkelsi-, nidkere-, nijiged, nijegel,
ne- neyi-<[*negi], neyid-, neyidke-, neyidkegesü, neyidkegeri, neyidkemel, neyidkere-, nedkel~nidkel, neyidem, neyile-, neyigen, neyigele-, neyigečile-, neyigem, neyigemji-, neyigemle-, neyigemlig, neyigemči, neyigemčile-, neyigemsi-, neyis, neyisle-, neyislel, neyite

Манж хэлэнд:

e-<[*ne] emu, emembihede /нэг нэгдээ/, emute /нэжгээд/, emuči /нэгдүгээр/, emetu /зарим нэг/, emhun /ганцаар/, emgeri /нэгэнт/, emursu /дан/, emde /хамтаар/, emke /нэгэн/, emken /нэгэн/, emgi /хамт/, emgile- /хамтад-/, emdengeri /нэжгээд тэг/, emteli /ганцаархан/, emtungge joton /дан ширхэгт зотон/, emdubei /байн байн/, emte /нэжгээд/,
omo- omolo /ач/
ne- neigen /нийгэн/, neigele- /нийгэл-/, neigenje- /нийгэтгэ-/
ni- nike- /түших, нийлэх/, niken /түшил/, nikeku /түшлэг/,

Манж, монгол хэлэнд “нэг” гэсэнтэй ойролцоо утгатай дараах төрөл үгс байна.

Монгол хэлэнд:

a- angq-a /анх/, angqan /анхан/, angqadaγüci /анхдагч/, angqala- /анхал-/, angqaduγar /анхдугаар/, ači /ач/
гань- ʎanira- /ганир-/, ʎaniraqara- /ганьхар-/, ʎaniraqaral /ганьхрал/, ʎangsara- /гансар-/, ʎangsaral /гансрал/, ʎaγča /ганц-гагц /, ʎaγčaqaγ /ганцхан-гагцхан/, ʎaγčaγar /ганцаар-гагцаар/, ʎaγča kü /гагцхүү/, ʎaγčaγarda- /ганцаард-/, ʎaγčaγardal /ганцаардал/, ʎaγčaγaji /ганцааж/, ʎaγčaγčin /ганцагчин/, ʎoni /гоонь/, ʎong /гон/, ʎongsui- /гонсой-/, ʎongsuγur /гонсгор/, ʎongsura- /гонсор-/
со- sodu /сод/, sodun /содон/, sonin /сонин/, sondui- /сондой-/, sonduγui /сондгой/, sonduγuγira- /

²⁷ Д. Төмөртоогоо, *Монгол хэлний тооны нэрийн бүтэц, тогтолцоо*. Монгол хэлшинжилэлийн онол, түүхийн асуудалууд, Улаанбаатар, 2002, 233-р тал.

²⁸ D. Tumurtogoo, *Preclassical Monuments of Uighur Mongol Script*, Collaboration with Cecegdari, Taipei, 2007.

²⁹ Ö. Manduqu, *Qiuwa i i iui*, 1998, 210-р тал-а.

	сондгойр-/ sonduuyiral /сондгойрол/, soqur /сохор/, soqurul /сохрол/, soljir /солжир/, sonji- /сонжи-/
өрөөл-	örügel /өрөөл/, örügesün<*örügelsün /өрөөсөн/, örügelde- /өрөөлд-/, örüges- /өрөөс-/, örügeske- /өрөөсгө-/, örügeskel /өрөөсгөл/
бэл -	belbesün /бэлэвсэн/, belbisüd /бэлэвсний олон тоо/, belbisüle- /бэлэвсэл-/, ³⁰ belbesüre- /бэлэвсэр-/, belbesürel /бэлэвсрэл/, belgerde- /бэлгэрд-/, belberkei /бэлбэрхий, бэрэвхий/, berbekei /бэрэвхий/, belčig /бэлчир/
бүр -	бүрмөсөн, бүрэн, бүгд, бүх, бүхэл, бүтэн
дан -	dang /дан/, dangna- /дагна/

Манж хэлэнд:

γa-	γayda /ганц/, γačuha /ганц бие/, γančuha /гон/, γayγa /өрөөл, өрөөсөн/ – γayγata /ганцагчин үсэг/, γayγadambi /өрөөсөд-/,
so -	sončoho /өрөөсөн cap/, sonio~soniohon /солжир/, sonin~soningγa /сонин/, sučungγa /анхдугаар/.
si -	sinayān /бэлбэсэн/, sinayala-/бэлбэсэр-/, silhata- /гань/, angγasi /бэлбэсэн/
dang -	dang /дан/

Эдгээрээс зарим үгийн үүсэл гарал, холбоо хэлхээний талаар тус өгүүлэлд холбогдохын учир тодруулан өгүүлэх хэрэгтэй болов уу.

Монгол хэлний “**анх**” гэдгийн “**а**” язгуур, дэс тооны утга бүхий ‘**сi**’ дагавар нийлэн хүүгээс дооших анхдугаар үеийн үр гэсэн утгатай “**ач**” гэдэг үг үүссэний нэгэн адилаар манж хэлний “**нэг**” гэсэн утгатай ‘**ети**’-ийн ‘**ото**’ хувилбараас ‘**омоло**’ /ач/ гэдэг үг үүсчээ. Түнгүсийн хэлнүүдийн нэгийн тооны нэр “**ети**”-ээс дэд үеийн уруулын эгшгийн нөлөөгөөр эхний үеийн эгшиг ухран ижилсэж хувирсан байгааг хүснэгт харьцууллаас харж болохын хамт, бараг цөмд нь “**ач**”-ийг “**омоло**” (эв. *омолгй, эвен. омоло, нег. омологй, омологичан, ороц. омолоэ~омоли, уд. омоло, зөр. омоло*), хамниган хэлнээ *асii* гэнэ. Эндээс монгол, манж хэлэнд үе залгамжаа нэрлэсэн нэр нь утгын болоод хэлбэрийн талаар лавтай тохирч буйг харж болох юм. Уйгур, түрэг хэлээр ‘**ати**’ хэмээдэг нь цаашлаад, нийт алтайн хэлэнд түгээмэл буйг илтгэж байна.

Монгол хүний үе удмаа нэрлэх үг дээрхийн адил *үндсэн тооны нэрийн язгуур+ ‘сi’ бүтээвэр* гэсэн загвараар, *жич, гуч, дөч, тач* гэж бүтжээ. Харин манж нар ачаас хойших залгамж угсаагаа задлаг аргаар *ᠵᠢᠮᠡᠰᠢ ᠵᠠᠯᠠᠨ ᠢ ᠵᠢ- үгчилбэл: хоёрдугаар үеийн хөвүүн, мо. жич/, ᠵᠢᠮᠡᠰᠢ ᠵᠠᠯᠠᠨ ᠢ ᠵᠢ- үгчилбэл: гуравдугаар үеийн хөвүүн, мо. гуч/, ᠵᠢᠮᠡᠰᠢ ᠵᠠᠯᠠᠨ ᠢ ᠵᠢ- үгчилбэл: дөрөвдүгээр үеийн хөвүүн, мо. дөч/, ᠵᠢᠮᠡᠰᠢ ᠵᠠᠯᠠᠨ ᠢ ᠵᠢ- үгчилбэл: тавдугаар үеийн хөвүүн, мо. тач/ гэж нэрлэдэг. Дашрамд, монгол хэлний эдгээр үгсийг *анхдахьч>ач, хоёрдахьч>жич (хоч), гуравдахьч>гуч, дөрөвдэхч>дөч, тавдахьч>тач* гэж үүссэн, “-дахь, дэх, -ч гэсэн хоёр дагавар нь хоёулаа дэслэх дугаарлах утгатай учраас эхний бүтээврийн үүрэг суларч хураагдан, ‘-ч’ дагавар нь язгууртаа наалдаж үүссэн”³¹ гэж үзсэн зүйл буй.*

³⁰ Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалуудад, *belbisüd*-i Таq.14аб, *belbisülekü* Таq.36б5 зэргээр “**i**”-тэй тохиолддогийг жишээнд уг хэвээр нь авлаа.

³¹ Б. Пүрэв-Очи *Монголчуудын уламжлалт тоозүй, хэмжилзүйн нэрээс үүдэж хийсэн зарим ажиглалт*, Mongol Studies /Korean Association for Mongol Studies/ 1999, №8, p.163-175

Мөн манж хэлэнд “анхдугаар хүү буюу ууган” гэсэн утгатай “aji” хэмээх үг буй нь дээрх “а” язгуураас үүсэлтэй бөгөөд бүтээврийн хувьд ч зөрүүгүй. Зөрчин бичгийн дурсгалд 疾 莽 (*ajir anie) анхдугаар он, анхны жил хэмээсэн утгатай хэллэг тохиолдох бөгөөд үүний ажир *ajir –нь “Хуа и и юй” толь бичигт 疾得尔 (*ajir morin) буюу “унага” гэсэн үгэнд бий.³² Гурван наснаас дээших агтлаагүй адуу, илжгийг хэлэх 疾得尔 / ajirγ-а буюу азарга/ ч үүнд холбогдоно. Дундад үеийн Солонгос хэлэнд “анхны удаа” гэсэн утгатай ‘azi’ хэмээх үг байдаг ба энэ үеийн солонгос хэлний хоёр эгшгийн дундах z нь манж хэлний адил байр дахь “s, j” -тэй тохирдог.³³

Манж хэлний “ya-“ язгуурт үгсийн тухайд үе гишүү /yaγan/ хэмээсэн үгээс үүсэлтэй бөгөөд ижил хос салаа салбар нь үгүй аваас зохисгүйдэх гэсэн санаагаар “yaryadambi” /өрөөсөд-/ гэж ганцын зохисгүй талыг илэрхийлдэг байна. Монгол сэтгэлгээгээр, угаас заяамал хос юмын нэгийг нь “өрөөсөн” гэдэг үгээр хэлж, тийнхүү жам номоороо хос баймаажин тэгш биелдэг тийм зүйлийн нэг нь дутаж гуцахад “өрөөсөн”-ийх нь чадал хүчин мөхөстөхийн учрыг илтгэх “өрөөсөд” гэсэн үг бүтээх зэргээр бүтээврийн утгаар язгуурыг чимэн дэлгэрүүлж, дараа дараачийн үгс бүтжээ.

Өмнө дурдсан монгол хэлний “бэл-“ язгуурт үгс, манж хэлний нийдэм нийтээр гэсэн утгатай “bireme” хэмээх үгийн гарлыг түрэг хэлний “bir” /“нэг”-ийн тооны нэр/-тэй холбож үзэх нь маргаангүй зүйтэй юм. Түрэг хэлний энэ үгийг “байх” гэсэн утгатай монгол хэлний “буй”, солонгос хэлний “ida”, түнгүс хэлний “bi” болон биеийн төлөөний үгтэй холбож үзсэн зүйл бий.³⁴ Ш. Цэцэнцогт “бяруу” гэсэн үгийн “bir”-ийг түрэг хэлний “нэг” гэсэн үгтэй гарал нэг байж болох, борлон, буурж зэргийг ч мөн үүнтэй нэг гаралтай хэмээж³⁵, М. Базаррагчаа түрэг хэлний “би-р”-ийг “би” хэмээх биеийн төлөөний үгтэй гарал нэгтэй, монгол хэлний “бүри” нь “и-ү” эгшгийн сэлгэцээр бий болж, улмаар бүрэн, бүтэн, бүх, бүхэн, бүхэл, бүгд зэрэг төлөөлөх үглэврүүд бий болсныг дурджээ.³⁶ Ц. Шагдарсүрэн түүхэн сурвалжид тохиолддог ганцаардахын утгатай “бэлгэрд-” гэсэн үгийг шинжлэн, бэлэвсэн, бэлчир зэрэг үгстэй язгуур нэг болохыг тодолж, улмаар монгол хэлний “бэл-“ язгуурыг яргуулан хөөж тусгайлан илтгэл тавьж, өгүүлэл нийтлүүлсэн билээ.³⁷ Эдгээр эрдэмтдийн саналыг бүрэн дэмжиж буй тул амьтны шилбэ, тагалцаг хоёрын уулзар газрыг хэлэх “бэлбэрхий” буюу “бэрэвхий” гэсэн үгийн жишээг бас дурдъя. Манжийн fuhali /нэгмөсөн/, uhele- /нийчил-/, uhereme /бүгд, цөм, нийт, ерөнхий/, uheri /бүгд/, uhei /бүгд, бүгдээр/, gubci /бүх, хөвч/, gullhun /бүхэл/ зэрэг ч энэ bel-, bir язгуурт холбогдох юм.

Жич, Монгол хэлний бүрмөсөн (bürimüsün < *birmüsün), нэгмөсөн (nigemüsün), хоймсон (qoyimusun < *qoyirmüsün), жирэмсэн (jirmüsün), гурамсан (yurmusun), дөрөмсөн (dörmüsün) гэсэн үндсэн тооны нэр дээр ‘-musun/-müsün’ дагавар залгаж бүтсэн үгсийн манж хэлэнд дүйх үгс нь emursu (дан, нэг давхарга), jursu (хоёр давхар буюу хос), ilarsu (гурван давхар),

³² Daniel Kane, *The Sino-Jurchen vocabulary of the Bureau of Interpreters*, Indiana University, 1989, p.22.

³³ Ki Moon Lee, *A comparative study of Manchu and Korean*, Ural Altaische Jahrbücker, XXX, 1958, pp.150.

³⁴ Л. Болд, *Түрэг, монгол хэлний тооны нэр*, Улаанбаатар, 2005, 16-17 –р тал.

³⁵ Sečenčoytu, *Mongyol üges-ün ijaγur-un toli*, ÖMAKQ, 1988, 736-r tal-a.

³⁶ М. Базаррагчаа, *Монгол үгийн гарлыг мөшигх нь*, IY, Улаанбаатар, 1995, 369-370 –р тал.

³⁷ Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний bel- язгуурын утга учир...*, Acta Mongolica, Vol.4 (236), Улаанбаатар, 2005.

yūsu (гурамсан), *idursu* (хэдэн давхар) бөгөөд хэлбэрийн хувьд “**тооны нэрийн язгуур+ursu** (ма. *давхар гэсэн утгатай үг*)” гэж үг нийлж бүтсэн байдалтай аж. Дагаврынх нь тухайд М. Базаррагчаа “*бүтэн*” гэсэн үгээс үүсэлтэй,³⁸ Ш. Сэцэнцогт, аливаа юмны нарийн иш гэсэн утгатай “*mösü*” гэсэн үгийн *утас*, *дээс зэрэг нийтгэмлийн нэг хувийг* илэрхийлэх хоёр дахь утгатай нь холбож,³⁹ М. Баярсайхан *та. -ursu* < **mursun/bürsün* > *mo.musun*, **mursun* дагавар ма. *tudan* (*удаа*), мо. *udaγ-a* –тай гарал нэг байж болох юм хэмээсэн буй.⁴⁰ “*musun*” дагавар “*emursun*”-ээс үүдэлтэй байж болох юм.

Эдгээр үгсийн давтамжийг сурвалж бичгүүдээс ажиглавал, XVII-XVIII зууны үеэс илүү идэвхтэй хэрэглэгдэж, бичиг зохиолын хэлэнд олонтаа тэмдэглэгдсэн байдал ажиглагдаж байна.⁴¹ Жирэмсэн хүнийг *давхар биетэй*, *бие давхар* зэргээр мөн хэлдэг. Өнөөгийн “*жирэмсэн*” гэдэг утгаар одоогоор олдоод буй монгол бичгийн дурсгалд цагийн хувьд анхлан тэмдэглэгдсэн нь “... *жирэмсэн хүмүүнээ*” хэмээн Турфаны цуглуулгад хоёр удаа⁴² бөгөөд үүнтэй ойролцоо үеийн сурвалжуудад “*хээлтэй эм*” хэмээдэг байсан нь яваандаа “*хээл*”-ийг зөвхөн малын тухайд *хээл авах*, *хээл алдах*, *хээлтэй хонь*, *хээлтүүлэх* зэргээр хэрэглэх, хүний тухайд “*жирэмсэн*”-ийг хэрэглэх утгын ялгамжаатай болжээ. Ийм ялгамжаа XVII-XVIII зууны үе гэхэд нэгэнтээ тогтвортой болсон буй. “*Чингис хааны алтан товч нэртийн цадиг*”, “*Хураангуй алтан товч*”, Мэргэн гэгээний “*Алтан товч*” зэрэг түүхэн сурвалжид нэг удаа:

“...*Дээлийн давхар үл дааруулам гэлээ*
Дээсний гурамсан үл тасрам гэлээ...”

*гэж*⁴³ тохиолдож буй жишээнээс “*дээсний гурван давхар нь*” гэсэн утга ил байна.

“*dang*” –ийн тухайд, хятад хэлний 𐰃𐰆/*dan*/ гэсэн үг бөгөөд манж, монгол хэлний аль алинд оржээ. Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалд “Субашид”-ын VIII-ын 11а-д “... *Arslan jaya:n taulai qoyar-i dang nigen kičige:l-iyе:r alan bui.*” гэж нэг удаа, “*Бурхны арван хоёр зохионгуй*”-н 9б-д “... *qan köbegü:n Sarati-a:ča asaγu:r-un: Ülü ködelün gedergü kebtejü olan-a dang-dur ergügü:lügsen üsün-iyе:n čičalju eldebčilen ugi:laya:d ...*” гэж нэг удаа буюу нийт ердөө хоёр удаа тохиолдож буйгаас, дөрвөлжин бичгийн дурсгалуудад үгүй, *үйл лай*, *улс гүрэн*, *өш хонзон* гэхчлэн харь хэлнээс орсон үг тухайн хэлнийх нь утга дүйх үгтэй хоршин хэрэглэгддэг зүй тогтлоор “*дан нэгэн*” гэж хоршсон байдлаас, мөн орчин цагийн монгол хэлэнд уг язгуураас үүсэж, түгээмэл хэрэглэгдэх болсон “*дагна-*, *дагнаа*, *дангаар*, *дангаарчил-*, *дангаарчлал*, *данчил-*, *данд-* /*дан нь зохисгүйдэх*/, *дандаа*” зэрэг үгс энэ үеийн дурсгалд хараахан тохиолдохгүй байгаа зэргээс энэ үг дундад үеийн монгол хэлний үед шинэ тугтам орсон байж болох юм.

³⁸ М. Базаррагчаа, *Монгол үгийн гарлыг мөшгих нь*, II, Улаанбаатар, 1992, 303-р тал.

³⁹ Сеценбоџту, *Mongyol üges-ün iγayur-un toli*, ОМАКQ, 1988, 1426-г тал-а

⁴⁰ М. Баярсайхан, *Манж бичгийн хэлэн дэх гийгүүлэгчийн сугарал*, Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, Боть XIX (193), Улаанбаатар, 2003, 31-р тал.

⁴¹ *Монголын түүхэн сурвалжийн цуврал*, № I - XXX, Улаанбаатар, 2006.

⁴² D. Tumurtogoo, *Preclassical Monuments of Uighur Mongol Script*, Collaboration with Cецегдари, Taipei, 2007, pp.93.

⁴³ *Чингис хааны алтан товч нэртийн цадиг*, Монголын түүхэн сурвалжийн цуврал, №3, Улаанбаатар, 2006, 216-р тал, Ш. Чоймаа, *Qad-un ündüstün quriyangγui altan tobči*, (Эх бичгийн судалгаа), Улаанбаатар, 2002, 48-р тал,

Mo. qoyar / jirin – Ma. juwe

1. Монгол	qoyar/jirin	18. Эвен	ᠵᠡᠫ
2. Дагуур	хојir ~ хоir hoire, jiee	19. Солон	ᠵᠠᠰ
3. Зүүн ёгор	үүр	20. Негидал	ᠵᠠᠰ
4. Могол	qoyor	21. Ороц	ᠵᠠᠰ(p)
5. Баоань	буар	22. Уд	ᠵᠠ
6. Монгор	бөр	23. Ульч	ᠵуэл
7. Дунсян	буа	24. Орок	зү
8. Халимаг	хой ыр	25. Нанай	ᠵуэр
9. Дөрвөлжин бичиг	ᠪᠴᠡᠨ qoyar	26. Турк	iki
10. Монгол и и юй	舌腰兒 qoyor	27. Чуваш	ikē
11. Хуа и и юй	豁牙兒 qoyar	28. Тува	ийи (iji)
12. Араб үсгээрх монгол урсгал	qoyar	29. Якут	икки
13. Халимаг	хойер	30. Уйгур	икки
14. Манж	juwe	31. Узбек	икки
15. Зөрчин	二 juwe/dzo	32. Башкир	ішке
16. Хамниган	jür	33. Татар	ішке
17. Эвенк	ᠵᠠᠰ	34. Шар уйгур	ішке
		35. Тофалар	ih'i

Дагуур хэлний “jiee”-г Самуель Мартин *хоёрдахь* гэсэн утгатай гээд, “jiee hui” - the 2nd person (хоёрдахь хүн) гэсэн жишээ авч, үндсэн тооны нэрийн дотор оруулаагүй нь энэхүү ‘jiee’ нь дэс тооны утгыг илүүтэй илтгэдэг болсноос бололтой. “ji” язгуур нь зургаагийн тооны нэрийн бүтцэд буй. Дээрх харьцууллаас уг тооны нэр нь дараах бүтэцтэй байна:

монгол төрлийн хэлэнд: “*qo~xo~bu*” язгуур + “*ya, ji, a, iy*” язгуур + “*r*” бүтээвэр
манж-түнгүс хэлнүүдэд: “*ju~ᠵᠠ*” язгуур + “*we~e*” ~ “*r-l*” бүтээвэр

Дундад үеийн монгол хэлэнд “2” гэсэн утгатай хоёр үг байсны эр хүйс заах үг нь ‘qoyar’, эм хүйсийг заах үг нь ‘jirin’ байв. “qo-”, “ji-” язгуур нь эртний монгол хэлний онцлогийг илүүтэй хадгалан үлдсэн дагуур хэл, манж-түнгүсийн хэлнүүдэд болон монгол хэлэнд буй. “Хоёр”-ын тооны тухай өмнө олон эрдэмтэд судалж,⁴⁴ ойр орчныг бүхэлд нь хамаргасан чихмай чамбай судалгаа ч гарсан билээ.⁴⁵ Профессор Г. И. Рамстедт “*жирин*”-ий эртний хэлбэрийг “*zirin*”, “*хоёр*”-ынхыг “*qojir*” гэж үзсэн байдаг.⁴⁶ Академич Д. Төмөртоогоо “*ji-r-n*” гэсэн морфемуудад задлаад, язгуур морфемийн утгыг *ji, *ji гэсэн хувилбартай байсан, “-r-” ийг тооны нэрийн үндэс үүсгэх морфем, “*r, ri, re, rin, ren*” зэрэг хувилбартай бололтой, “*хоёр*”-ын тухайд олонх тооны нэрийн адил язгуур ба залгавар морфемоос бус, харин “*хоёр*”-ын утгатай хоёр язгуур морфем болох “qo”, “jir”-оос бүтсэн хэмээн үзжээ.⁴⁷

⁴⁴ Д. Төмөртоогоо, *Монгол хэлний “хоёр” хэмээх тооны нэрийн бүтцийн асуудалд*, 1969, Монгол хэлшинжилэлийн онол, түүхийн асуудалд, Улаанбаатар, 2002, 246-249 –р тал; С. Дулам, Монгол бэлгэдэл зүй, I, *Тооны бэлгэдэл зүй*, Улаанбаатар, 1992, 2007, 35-46-р тал, М. Базаррагчаа, *Монгол үеийн гарлыг мөшгөх нь*, II, Улаанбаатар, 1992, 183-199-р тал, Л. Болд, *Түрэг, монгол хэлний тооны нэр*, Улаанбаатар, 2005, 16-20 –р тал...

⁴⁵ Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний “qoyar/jirin” гэдэг тооны нэрийг мөшгөсөн нь*, Acta Mongolica, Volume 3 (215), Centre for Mongol Studies, Улаанбаатар, 2003, 33-54 –р тал;

⁴⁶ G. J. Ramstedt, *Über die Zahlwörter der Altaischen Sprachen*, JSFOu, 24:1, 1907, S.6;

⁴⁷ Д. Төмөртоогоо, *Монгол хэлний тооны нэрийн бүтэц, тогтолцоо*, (1980), Монгол хэл шинжлэлийн онол, түүхийн асуудалууд, Улаанбаатар, 2002, 236-р тал; *Монгол хэлний “хоёр” хэмээх тооны нэрийн бүтэцийн тухай асуудалд*, MC VII:22, 1970, 281-282-р тал; Монгол хэл шинжлэлийн онол, түүхийн асуудалууд, 2002, 247-р тал.

Бид монгол, манж хэлний “2”-ын тооны нэрийг гарал нэгтэй бөгөөд бүтцийн хувьд доорх байдлаар салбарлан үүсчээ хэмээн үзэж байна.

1. qo + ya~ja~ji + r > qoyar [mo.]
2. *ji + r + ben > jirin [mo.]
*ju + r + ben > juben > juwen > juwe [ma.]

Үүнээс, монгол хэлний “qoyar” нь “2”-ын утгыг илтгэх “qo” болон “ja~ya” (мо. *jayur-a, jai, jab; ma. jai, jačin г.м үгсийн язгуур*) хэмээх хоёр язгуур болон тооны нэр бүтээх “r” бүтээврээс бүтсэн байна. “qo-” язгуурын араас “-r-” бүтээвэр шууд залган орсон байдлыг “qorin” гэсэн тооны нэрээс харж болно. Манж болон монгол хэлний “juwe, jirin” нь “ji~ju” язгуур ба тооны нэр бүтээх “r” бүтээвэр, нэгчийн орны тооны нэр бүтээх “ben” бүтээвэр гэсэн ижил гурамсан бүтэцтэй аж.

‘ji’ язгуурын ‘i’ нь ‘u’-тэй сэлгэсэн, дээр нь тооны нэр бүтээх ‘ben’ дагаврын гийгүүлэгч суларсан хувилбар ‘wen’-ийг залгаснаар манж хэлний “хоёр”-ын тооны нэр “juwe” бүтжээ. Манж хэлний *juru /хос/, jursu /давхар/, түнгүсийн хэлнүүд дэх ‘jur, žur’, монгол хэлний jirin, jirim, jirmüsün* зэрэг үгэнд түшиглэн ‘juwe’ нь эртдээ ‘jurwen’ хэлбэртэй байсан гэж сэргээж болно. Цаашилбал, манж хэлний “juwe” нь *j < *d* гэсэн авианы хөгжлийн ёсоор < *duwe –ээс үүсчээ. Дундад үеийн солонгос хэлэнд “*tui r, tur*” хэлбэртэй байв.⁴⁸ Энэхүү “du” язгуур нь хошоод зүйлийн шинж байдлыг зэрэгцүүлж дэнсэлж үзэхийн утгатай “дүй-” (*düyi-, düyiče-, düyičel, düyilge-* г.м) язгууртай холбогдоно.

‘qoyar’, ‘jirin’, ‘juwe’-тэй гарал нэгтэй үгс:

Монгол хэлэнд:

- qo- qoos, qoosla-, qooslal, qoosmay, qoosmaljin (*qooslamaljin), qoyar, qoyarda-, qoyardamal, qoyarqan, qoyaduγar, qoyarla-, qoyarta, qoyayul, qoyiči, qoyimusun, qojim, qonji-, qonjisu, qonjiγ-a, qonjiγasu, qob, qobusu, qobil, qoγur, qoγurundu, qoli-, qolim-a, qolil, qolilta, qolildu-, qolimay, qolimča-, qolimčay-a, qoliy-a, qoliyan, qoliyaldu-, qoliyasu, qolisi, qolisila, qoliča, qoličay-a, qolbu-, qolbura-, qolbuγ-a, qolbuγalji, qolbuγaljin, qolbuγasu, qolbuγatan, qolbuγači, qolbuγačin, qolbuγara-, qolbuγda-, qolbuγdal, qolbulta, qolbuljin, qolbuča qori, qorin, qoriqan, qoriduγar, qorinta, qorsi-, qorsiy-a, qorsiyala-, qorsiyalal, qorsiyaji-, qorsiyajil, qorsiyajiγul- qorsiyajiγulul, qosi, qosilang, qosila-, qosilayur, qosimay, qosiyu, qošong, qoči, qočila-, qočilal, qotul, qorbusu
- ja- jai, jayila-, jayiburi, jaičila-, jaiγul, jayimča-, jayal, jayur-a, jayura-, jab, jabdu-, jabqa-, jabqara-, jabqaral, jabqai, jabqayira-, jabsar, jabsarla-, jabsarlay-a, jabsarlayan, jalya-, jalyay-a, jalyayasu, jalyayalji, jalyayda-, jalyaldu-, jalyalduyan, jalyalta, jalyača, jalyamji, jalyamjila-, jalyamjilal, jalyamjilayči
- ji- jib, jibegüni, jibegüče-, jibegüčel, jiber, jidüger, jige, jigenčir, jig, jigi-, jigirig, jigirigle-, jigür, jigürten, jigürle-, jiyu-, jiyulčin, jiyulčila-, jiyulčilal, jirin, jirim, jirmüsün, jirmüdüsü, jiryuyan, jiran, jirüke, jilii-, jilay-a, jisur, jisurda-, jisurdal, jisurči, jisuy, jiši-, jišig, jišigle-, jišiγ-e, jišiyele-, jiči, jičinčir

⁴⁸ Ki-Moon Lee, *A Comparative study of Manchu and Korean*, Ural-Altische Jahrbucher, XXX, 1958, p.113

jo- joki-, jokis, jokistan, jokistu, jokildu-, jokilduly-a, jokiya-, jokiyanгыуи, jokimda-, jokimdayu, jokira-, jokiral

Манж хэлэнд:

ja- jai /жич/, jačin /хоёрдугаар/, jaqa /завсар/, jaqanambi /завсардмүй/, jalin /мүлд/
 ji- jibsi- /давхац-/,
 ju- juwe /хоёр/, juwete- /хоёрд-/, juru /хос/, juruken /хосхон/, jurule- /хосол-/, jurungge yasha /ижил шувуу/, jurutu alin /холболжисн уул/, jursu /давхар/, jursule- /давхарла-/, jude /хос алд/, juwerke /хоёр чавхдаст/, jutungya /jutungya joton – хос ширхэгт зомон/
 ho- hoki /хоршоо/, holbo- /холбо-/, holbon /холбоо/, holbongyo /холбоом/, holboqū /холбоос, хадаас/, qos /хов хош/

Эдгээр үгсээс “qo-” язгуур нь хоёр тусдаа зүйлийг нэгтгэж нийлүүлэх, холбож холихын. “ji-” язгуур нь нэг нийдэм зүйлийг салгаж зүсэхийн утгатай хэмээн ерөнхийлөн үзэж болох юм. Залгах, холбох, үргэлжлэхийн санааг илэрхийлэх манж үг нь *sira-* (*siranuhai, siranduhai /залгалдаагаар/, siran siran i /дараа дараагаар/, siraqū /залгаас/, sirabun /үргэлжлэл, залгамж/, sirabungya /залгамжлалт/, sirame /залгаж, дараа, удаа, залгаа/ г.м.) тул дурдсан “ho-” язгуурт үгс монгол хэлнээс орсон бололтой.*

Монгол хэлнээ “хоёр”-той ойролцоо утгаар хэрэглэгддэг ‘*ikir-e*’ /ихэр/ хэмээх үг түрэг хэлний хоёрын тооны нэр ‘*iki*’-ээс гаралтай бөгөөд түргээс монгол хэлэнд орж, зөрчинөөр ‘*ikiri*’ хэмээдэг нь монголоор уламжилж, улмаар манжид ч тэр хэвээр орсон аж. Сурвалж бичгүүдэд ихэр төрснийг, олонход нь Мандухай сэцэн хатны нуган үрсийн төрснийг өгүүлэхдээ “*төгс, төгс бүлгээ, төгс төрөв, төгс үзэгдэв, төгс эсэнлэв*” гэсэн бол⁴⁹ цөөн зарим сурвалжид “*ихэр*” гэсэн үгээр илэрхийлсэн байдаг.⁵⁰ Монголчууд аливаад хэлбэрүү хазгайгүй, хэм тэгш байхыг эрхэмлэдэг ард түмэн. Тиймээс ч өрх үүсгэн сум сунгасан хоёрыг *хос холбоо*, тэгш тоот саруудыг *төгс сар*, төрүүлсэн эцэг эхийг *төгс ураг*, төрсөн ихэр хүүхдийг *төгс* хэмээн нэрийддэг ажээ. Энэ нь “*Хөх судар*”-т *хос төгс* гэж хоршуулан шүлэглэсэн нь⁵¹ ойролцоо утгатай үгс хорших зүй тогтлын дагуу “*төгс*” гэсэн үг “*хос*” гэсэн утгатай болохын давхар нотолгоо юм.

Бас нэгэн сонирхол татахуйц зүйл бол Ломи бээр “*Тэндээс Мандухай сайн хатан Төрболд*.”

⁴⁹ Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, Улаанбаатар, 2006: *Чакраварди Алтан хааны тууж*, №4, 16-р тал; *Хаадын үндсэн хураангуй алтан товч*, №5, 108-109 –р тал; Лувсанданзан, *Алтан товч*, №6, 199-200 –р тал, 261-р тал; Саган сэцэн, *Эрдэнийн товч*, №8, 126-р тал; Гомбожав, *Гансын урсгал*, №10, 20-р тал; Рашипунцаг, *Болор эрих*, №14, 548-р тал; Дарма гүүш, *Алтан хүрдэн мянган хигээст*, №15, 84-р тал.

⁵⁰ *Тэндээс Мандухай цэцэн хатнаас төрсөн Төрболд, Улсболод хоёр ихэр, Барсболод, Арсаболод хоёр ихэр, Очирболод, Алчуболод хоёр ихэр, Алболод, Гэгээн-абай хоёр ихэр буюу...* гэх зэргээр Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, Улаанбаатар, 2006: *Эртний Монголын хаадын үндэсний их Шар тууж оривой*, №7, 70-р тал; Жамба, “*Асрагч нэртнийн түүх*”, №9, 55-р тал, 70-р тал; *Монголын оронд хааны угсаа хийгээд шааши дэлгэрсэн, шашиныг баригчин үеэг урласан, хийд аймаг тэргүүтэн ямар мэт гарсны ёсыг номлосон эрдэнийн эрих оривой*, №19, 29-р тал.

⁵¹ ...*Мохули, Тайцзу-д улаан булигаарын алтан угатз зурсан уул усны магнаг хатгалалт нэгэн ороосон түрийт гутал ацарч барив. Тайцзу үзмэгц сэцэн ухааныг нь мэдээд мүйсэмсэглэн, хоёр гараар тосон авч: “Хос төгс болсон хойно, хоцролгүй өмсүгэй” хэмээн харцуд өөрөө унах салхин цав нэрт хүлэг морио ороосон мөнгөн дорөөтэй, эмээл хазаартай шагнан өгөв.*

Улусболдыг ихэр төрөв. Дараа Барсаболд. Арсаболд басхүү ихэр төрөв. Дараагаар Очиболд, Анчуболдыг ихэр төрөв. Дараагаар Алаболд, Торолт гүнжийг ихэр төрөв. ... Ихэр хэмээсэн үг төгс үзэгдэхүйг өгүүлсэн нь.” гэжээ.⁵² Энэ үг тухайн цагийн тэр нутгийн олонд түгээмэл хэрэглэгддэггүй, харь гаралтай, утга нь ойлгогдож буух болголоо идээшээгүй байсны улмаас ийнхүү монголоор тайлбарлаж оруулсан биз ээ.

Зарим эрдэмтэд “дэнс”-ийг *дэд*, *дэс* *дэм*-тэй холбож, хоёрыг тэнцүүлэхийн утгатай хэмээсэн нь бий. **d > j* үүссэн хувирлаар *дэс*, *дэд*, *дүй*- зэрэг олон үг “2”-ын тооны язгууртай эртний садан. Манж монгол, хэлэнд үгийн аль ч үед “*d~j*” гийгүүлэгч өөр зуураа таарах байдал тохиолддог. Жишээ нь:

мо. medege - ма. mejige
мо. jasaγ~yasaγ - ма. dasan

мо. domoγ - ма. jomci /дурс-/
мо. haγaγar - ма. hadala г.м.

Гэвч, “дэнс”-ийн хувьд манж, монгол хэлний хоёуланд орсон (ма. ~~дэнс~~ мо. ~~дэнс~~) хятад хэлний 戥子(deng zi) хэмээх үг. Ийм “zi” дагавар бүхий үгс ма. *ise*, мо. *исэр* < хя. 椅子(yi zi), ма. *puseli*, мо. *пүүс* < хя. 铺子(pu zi), ма. *dangse*, мо. *данс* < хя. 档子(dang zi), ма. *cese*, мо. *цэс* < хя. 册子(ce zi) гэхчлэн монгол, манж хоёр хэлэнд орохдоо “子”(zi/зы) нь “с” болох тохиолдол цөөнгүй.

Мо. yurban – Ма. ilan

1. Монгол	yurban	19. Негидал	илаја
2. Дагуур	ᠵᠢᠷᠪᠠᠨ	20. Ороц	ила(н-)
	guarebe, guarebᠡᠨ	21. Уд	ила(н-)
3. Зүүн ёгор	үүрван	22. Ульч	йла(н-)
4. Могол	qurban	23. Орок	йла(н-)
5. Баоань	бураң	24. Нанай	йлан(н-)
6. Монгор	бурāн	25. Турк	üç
7. Дунсян	буран	26. Чуваш	višĕ (višĕ)
8. Дөрвөлжин бичиг	ᠵᠢᠷᠪᠠᠨ qurban	27. Азербайжан	үш
9. Монгол и и юй	兀魯班 yuluban (yurban)	28. Казак	үш
10. Хуа и и юй	忽兒班 qurban	29. Тува	үш
11. Араб үсгээрх монгол дурсгал	yurban	30. Хакас	üs
12. Халимаг	hurvн	31. Якут	үс
13. Манж	ilan	32. Башкир	өс
14. Зөрчин	斗 ilan	33. Татар	өч
15. Хамниган	ilan	34. Киргиз	үч
16. Эвенк	ilalla/ilan	35. Уйгур	үч
17. Эвен	иллалтй	36. Шар уйгур	уш~үш
18. Солон	илā	37. Тофалар	üš

Монгол утга соёлд *ертөнцийн босоо загвар*, *цуваа цаг буюу дээд*, *дунд*, *доод тив*, *өнгөрсөн*, *одоо*, *ирээдүй цаг*⁵³, *орон зай*, *цаг хугацааг илэрхийлэх үндсэн нэгж*⁵⁴ -ийн шинжтэй хэмээн үздэг уг тооны нэрийн язгуур монгол төрлийн хэлэнд “*yu-*”, манж түнгүсийн хэлэнд “*илан*”, түрэг төрлийн хэлэнд “*үч~үш~үс*” аж. Түргийн “*үс*”-ийг Г. И. Рамстедт монгол хэлний *üšiken*, манж түнгүсийн *üšile* (хэмхлэх, хэсэглэх) –тэй, Т. А. Бертагаев, Н. Поппе, В. Котвич

⁵² Ломи, *Боржигид овгийн түүх*, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал №11, Улаанбаатар, 2006. 67-р тал.

⁵³ С. Дулам, Монгол бэлгэдэл зүй, I, *Тооны бэлгэдэл зүй*, Улаанбаатар, 2007, 79, 92-р тал.

⁵⁴ Д. Цэдэв, “*Монголын нууц товчоон*”-ы бэлгэдэлийн асуудалд, *Mongol Studies*, 1993, №1, 143-р тал.

нар монгол хэлний “*γиᠰ(in)*”-тай, К.К.Юдахин *и:ᠰ (amga-)*-тай холбон тайлбарласан буй.⁵⁵

Монгол хэлний “3”-ын тооны нэр нь “*γи*” язгуур + “*r*” бүтээвэр + “*ban*” бүтээвэр буюу бусад тооны нэрийн адил язгуур, бүтээвэр гэсэн бүтэцтэй, монгол төрлийн зарим хэлэнд хоёрдахь бүтээврийн гийгүүлэгч сугарсан байдалтай байна.

‘*γurban*’, ‘*ilan*’ -тай гарал нэгтэй үгс:

Монгол хэлэнд:

γи- *γurba~γurban*, *γurbaqan*, *γurbanta*, *γurbayad*, *γurbaduγar*, *γurbayula*, *γurbanča* /гурван хөлт домгийн амьтан/, *γurbasu* /гурван эвэрт гөрөөс/, *γurbada-* /гурав нь зохисгүйдэх/, *γurbal*, *γurbala-*, *γurbalji* /нэг зүйлийн зэгс/, *γurbaljin*, *γurbaljila-*, *γurbaljilal*, *γutuγar*, *γurmusun*, *γurmusula-*, *γuna~yunan*, *γunji~γunjin*, *γиᠰi*, *γиᠰinčar*, *γиᠰi~γиᠰin*, *γиᠰinta*, *γиᠰiγad*, *γиᠰiduγar*

Манж хэлэнд:

γи- *γūsū* < зөр. /гурамсан/, *γūna* /гуна/, *γūrbi* /ургамал/, *γūsūn* < зөр. /гуч, гучин/, *γūsinggeri* /гучинтаа/, *γūsiči* /гучдугаар/, *γūsita* /гучаад/
ilan- *ilan* /гурав/, *ilači* /гуравдугаар/, *ilači jalan i otolo* /гуч, гуравдугаар үеийн ач/, *ilanggeri* /гурвантаа/, *ilata* /гурваад/, *ilarsu* /гурамсан, гурван давхар/, *ilmoho usiha* /гурван марал од/, *ilari boso* /гурван утсан бөс /

Үүнээс манж хэлэнд буй “*γи*” язгуурт үгс нь монгол хэлнээс зөрчин хэлээр уламжлан орж идээшсэн үгс ба уугуул манж үгсийнх нь тухайд гурвын утгат “*ilan*” язгуураа тогтвортой хадгалсан гэж болно.

Mo. dörben – Ma. dūin

1	Монгол	dörben	18	Солон	ди
2	Дагуур	dürwē(н) durube, durubūen	19	Негидал	дијū
3	Зүүн ёгор	dörben	20	Ороч	дū
4	Могол	durbon	21	Уд	дū
5	Баоань	дэраң	22	Ульч	дуи(н-)
6	Монгор	дэран	23	Орок	дундатчи
7	Дунсян	джэруан	24	Нанай	дуй
8	Дөрвөлжин бичиг	ᠳᠣᠷᠪᠡᠨ dörben	25	Турк	tört
9	Монгол и и юй	都魯班 dülüben (dürben)	26	Чуваш	tävatä (tävattä)
10	Хуа и и юй	柴边的 dörben	27	Хакас	tört
11	Араб үсгээрх монгол	dörben	28	Киргиз	tört
12	дурсгал Халимаг	дервн	29	Тува	дөрт
13	Манж	dūin	30	Азербайжан	дөрд
14	Зөрчин	ᠳᠦᠢᠨ dūin	31	Якут	түөрт
15	Хамниган	degin	32	Башкир	дүрт
16	Эвенк	diᠰin	33	Казак	төрт
17	Эвен	дуйу	34	Узбек	турт
			35	Тофалар	döört-dört

⁵⁵ Г. И. Рамстедт, *Введение в алтайское языкознание (морфология)*, перевод с немецкого Л. С. Слоним, Москва, 1957, стр. 148, Т. А. Бертагаев, *Лексика современных монгольских литературных языков (на материале монгольского и бурятского языка)*, Казань, 1974, стр. 306, W. Kotwicz, *Contribution aux etudes altaïques II*, // RO, 1930, p. 157, Л. Болд, *Түрэг, монгол хэлний тооны нэр*, Улаанбаатар, 2005, 20-р тал.

Ертөнцийн хавтгай загвар, хам цаг буюу дөрвөн улирал, дөрвөн зүг⁵⁶ -ийн төлөөлөл болох энэхүү тооны нэр алтайн хэлнээ нэг гаралтай. Харьцууллаас:

Монгол төрлийн хэлэнд: “*dö/dü/de-tö/tü*” язгуур + “*r*” бүтээвэр + “*ben*” бүтээвэр

Түрэг төрлийн хэлэнд: “*dö/dü-tö/tü*” язгуур + “*r*” (*t*) бүтээвэр

Манж-түнгүс хэлнүүдэд: “*du~dū-de-di*” язгуур + “*Ø*” ~ “*in-gin*” бүтээвэр

гэсэн ерөнхий тогтолцоот бүтэцтэй байна.

Нийт алтай хэлэнд тохиолдох ‘*y~g*’ гийгүүлэгчийн сэлгэх ёсоор манж хэлний ‘*duin*’ нь ‘*dugin*’-ээс хөгжсөн болохыг хамниган, эвен, эвенк зэрэг хэлний баримтаас харж болно. Манж хэлний **jurwen* гэдгийн ‘*-r-*’ гийгүүлэгч сугарсны адил **durgin* байгаад ‘*-r-*’ нь сугарч, улмаар *dörben/dörge*n > **durgin ~dergin* > *dugin~degin* [хам. эв.] > *duyin* > *duin* гэсэн хөгжлийг туулж буй болсон гэж үзэх саналтай байна. Манжийн дөчийн тоог заах үг ‘*dehi*’-ийн ‘*de-*’ язгуур, баоань, монгор, дунсян, халимаг, хамниган, эвенк хэлний дөрвийн тоог илтгэх үгийн ‘*de-*’ язгуур зэргээс “*du, de*” язгуур сэлгэж байсан, магадгүй **de-* нь анхдагч байж болох юм.

Дашрамд, нэрт эрдэмтэн Н. Поппе эртний турк хэлний анхдагч урт эгшиг Туркмэн, Якут хэлэнд хадгалагдаж байна гээд жишээндээ “*дөрөв*”-ийн тооны нэрийг (*trkm. düört* ‘four’, *yak. tüört*) авсан байдаг.⁵⁷ Өмнө дурдаж байсанчлан манж хэл ч анхдагч урт эгшгийг хадгалсан⁵⁸ ба солон, ороц, уд зэрэг түнгүүсийн хэлний дөрвийн тооны нэр “*дү*” нь үүнд баримт болно.

‘*dörben*’, ‘*duin*’-тэй гарал нэгтэй үгс:

Монгол хэлэнд:

dö- *dörbe~dörben, dörbente, dörbege*d, *dörbedüger, dötüger, dörbegüle, dörbede-*, *dörbel, dörbele-*, *dörbeljin, dörbeljile-*, *dörbeljilel, döne~dönen, dönji~dönjin, döci, döcincir, döci~döcin, döcinte, döciged, döcidüger*

Манж хэлэнд:

du- *duin* /дөрөв/, *durbe* /дөрөв/, *durbejitu* /дөрвөлжин хэмжээ/, *duinggeri* /дөрвөн тоо/, *duite* /дөрвөөд/, *durbejen* /дөрвөлжин/, *durbejengge* /дөрвөлжим/, *duiči* /дөрөвдүгээр/, *duiči jalan i otolo* /жичинцэр, дөрөвдүгээр үеийн үр/, *duingge* /дөрөвт/,
de- *dehi* /дөч, дөчин/, *dehinggeri* /дөчинтөө/, *dehite* /дөчөөд/, *dehiči* /дөчдүгээр/, *deune* /донө/

Mo. tabun – Ma. sunja

1	Монгол	tabun	20	Ороч	туна
2	Дагуур	т’āў(н)	21	Уд	туңа
		taau, taau᠓	22	Ульч	туңза
3	Зүүн ёгор	тāвен	23	Орок	туңда
4	Могол	tabon ~ ika yar	24	Нанай	тојңга

⁵⁶ С. Дулам, Монгол бэлгэдэл зүй, I, Тооны бэлгэдэл зүй, Улаанбаатар, 1992, 2007, 92-р тал.

⁵⁷ Nicholas Poppe, *Introduction to Altaic Linguistics*, Otto Harrassowitz, Wiesbaden, 1965, pp. 177.

⁵⁸ Э. Мөнх-Учрал, Манж, монгол хэлний урт эгшигийг язгуур дүйх үгсийн хүрээнд харьцуулах нь, Acta Mongolica, Vol.5(246), Улаанбаатар, 2005, 101-р тал.

5	Баоань	тавоң	25	Турк	beş
6	Монгор	tāven	26	Чуваш	piñek (pillék)
7	Дунсян	тавуан	27	Тува	беш
8	Дөрвөлжин бичиг	ᠲᠠᠪᠤᠨ tabun	28	Азербайжан	беш
9	Монгол и и юй	搭奔 dabun (tabun)	29	Киргиз	беш
10	Хуа и и юй	塔奔 tabun	30	Узбек	беш
11	Араб үсгээрх монгол дурсгал	tabun	31	Хакас	пис
12	Халимаг	тавн	32	Якут	биэс
13	Манж	sunja	33	Татар	биш
14	Зөрчин	ᠰᠢ sunja	34	Башкир	биш
15	Хамниган	tunna ~ тунгма	35	Казак	бес
16	Эвенк	тунца	36	Уйгур	бэш
17	Эвен	тунцън	37	Шар уйгур	пес-дис
18	Солон	тоңа	38	Тофалар	beş
19	Негидал	тонна			

Монгол хэлний уг тооны нэрийн бүтцийн тухайд, Д. Төмөртоогоо “*tab-n гэсэн хоёр морфемоос бүрдэж байгаа бөгөөд *tab гэсэн эхний хэсэг нь тухайн тооны утгыг хадгалсан язгуур морфем*”⁵⁹, Л. Болд “...уул үгийн эртний хэлбэрийн бүтцийг нь *ta-bu-n~ta-ban* гэж задлахад тийм ч ноцтой алдаа болохгүй юм”⁶⁰ гэжээ.

Бид, монгол төрлийн хэлэнд анхдагч урт эшгээ хадгалж буй үгсийн нэг болох тавын тооны нэр (dag. tāvun, mngr. tāweŋ < *tāvun) нь: “**ta**” язгуур + “**bun~ban**” бүтээвэр (хувилбарууд) гэсэн бусад үндсэнд тооны нэрстэй адил бүтэцтэй байна гэж үзэж байна.

“Хуа и и юй толь”-д *taban* хэмээн дагавар бүтээврийг “a” эгшигтэй тэмдэглэсэн буй.⁶¹ Манж хэлний “*sunja*”-г Ки-Мүн И “*sunja*” < **susa* < **tusa*, МК. *tasas id. Cf. Tu. tunza, tunga, etc. id.*⁶² гэсэн буй. Түнгүсийн хэлнүүд дэх “*ту-мо*” язгуур болоод манж хэлний “*sunja*”-гийн “*su-*” язгуур нь “*m~c*”-ийн сэлгэцээр холбогдож, хамниган хэлний “*тунгма*”, нанай хэлний “*тојңа*”-гаас тооны нэр бүтээх ‘*man~yan*’ дагаврын эцсийн гийгүүлэгч нь гээгдсэн хувилбар байна. уг дагавар бусад түнгүсийн хэлэнд илүү хамаршсан байдалтай болжээ.

Язгуурын утгын тухайд, монгол хэлний “*тав*”-ыг Г. И. Рамстедт солонгос хэлний ‘*ta*’ (бүх, бүгд) хэмээх үгтэй холбож, дундад үеийн солонгос хэлний *ta-sal* (**ta-sasi*) хэмээх үгийн “*sal~sasi*” эртдээ “*гар, нударга*” гэсэн утгатай болохыг дурдаж⁶³. М. Базаррагчаа хадаасны *тав*, амьтны *тавхай*, *таваг*, *тавцан* зэрэгтэй гарал нэг.⁶⁴ С. Дулам бах тав нь ханахтай холбоотой, *tabu* нь тооны утгыг, *taba* чанарын утгыг илтгэнэ⁶⁵ гэж, түргийн ‘*beš*’-ийг уйгур хэлний *biläk*, татар хэлний *bäläk*, алтай хэлний *belek* (иуу, бүгүй)-тай холбож, шорс хэлний ‘*tabaš*’ (*гар, алга*), монгол хэлний ‘*tabay*’-ийг⁶⁶ харгалзах зэргээр үзсэн буй.

⁵⁹ Д. Төмөртоогоо, *Монгол хэлний тооны нэрийн бүтэц, тогтолцоо*, (1980), Монгол хэлшинжилэлийн онол түүхийн асуудалууд, Улаанбаатар, 2002, 238-р тал.

⁶⁰ Л. Болд, *Түрэг, монгол хэлний тооны нэр*, Улаанбаатар, 2005, 22-р тал.

⁶¹ Ö. Manduqu, *Qinwa i i iui*, 1998, 328-r tal-a.

⁶² Ki-Moon Lee, *A Comparative study of Manchu and Korean*, Ural-Altische Jahrbucher, XXX, 1958, p.117.

⁶³ Г. И. Рамстедт, *Введение в алтайское языкознание* (морфология), перевод с немецкого Л. С. Слоним, Москва, 1957, стр. 65.

⁶⁴ М. Базаррагчаа, *Монгол үгийн гарлыг мөшгөх нь*, II, Улаанбаатар, 1992, 218 –р тал.

⁶⁵ С. Дулам, Монгол бэлгэдэл зүй, I, *Тооны бэлгэдэл зүй*, Улаанбаатар, 1992, 2007, 98-99 –р тал.

⁶⁶ Л. Болд, *Түрэг, монгол хэлний тооны нэр*, Улаанбаатар, 2005, 22-р тал.

Ер нь тавын тооны нэрийг дурдсан аль ч хэлэнд “гар”-тай холбож буй нь учир шалтгааны талаас ч ташаа зүйл бус төдийгүй “гар”-ыг өөрийг нь тооны нэгчийн нэр болгон тоолох уламжлал могол хэлэнд бий. Тодруулбал, монгол, дагуур хэлний адил XIII-XIV зууны үеийн монгол хэлний шинжийг зарим талаар харьцангуй тогтвортой хадгалж, мөн тухайн цагт хэлнийх нь хөгжилд нөлөөлж болох бусад монгол хэлнээс холдож тасарсан⁶⁷ могол хэлэнд тавын тоог дээрх харьцуулсан хүснэгтэд үзүүлсэнчлэн ‘tabon’ гэхийн хамтаар ‘ika yar’ (нэг гар) хэмээх бөгөөд 5-аас цааш энэхүү тооны нэгч нэр дээр “нэг гар нэг хуруу” нэмэх замаар тоолдог аж. Жишээлбэл, ‘nikan yar nikan qurū’= 6 гэх маягаар тоолох ба ‘nika yar durbôn óada’ /нэг гар ба дөрөв/ нь =9, “хоёр гар” нь “10”-ыг илэрхийлнэ.

‘tabun’. ‘sunja’-аас гарсан үгс:

Монгол хэлэнд:

tabu- tabun, tabunta, tabuyad, tab:idiyar, tabuyula, tabuly-a /ургамал/, tabulyan-a, tabulji /ургамал/, tabuljin /таван өнцөгт/, tuulan /*tabulan/, tabula-, tabi, tabidiyar, tabinta, tabiyad, tabiyula, tabidiyar

манж хэлэнд:

sunja- sunja /тав, таван/, sunjata /таваад/, sunjanggeri /тавантаа/, sunjači /тавдугаар/, sunjari suje /таван ширхэгт торго/, sunjangya inenggi /тавт өдөр, таван сарын таван/, sunčehen /таван сөл/

Mo. jiryuyan – Ma. ninggun

1	Монгол	jiryuyan	19	Ороч	жайуну
2	Дагуур	ᠵᠢᠷᠦᠭᠠᠨ(н)~ᠵᠢᠷᠦᠭᠦᠨ	20	Уд	нуну
		jirеuоо, jirеuоn	21	Ульч	нунгу(н)
3	Зүүн ёгор	джуруюн	22	Орок	нунгу
	Баоань	джирёон	23	Нанай	нунгиз
5	Монгол	джирёон	24	Турк	alti
6	Дунсян	джырбуан	25	Чуваш	ultä (ulttä)
7	Дөрвөлжин бичиг	ᠵᠢᠷᠦᠭᠠᠨ jirqo’an	26	Хакас	алты
8	Монгол и и юй	只魯蠻 jilu’uan (jiru’uan)	27	Азербайжан	алты
9	Хуа и и юй	只兒瓦安 jir’ua’an	28	Башкир	алты
10	Араб үсгээрх монгол дурсгал	jiryu’a:n, jiryu:n, jiryu’a:n	29	Татар	алты
11	Халимаг	зурган	30	Казак	алты
12	Манж	ninggun	31	Киргиз	алты
13	Зөрчин	ᠵᠢ ninggu	32	Тува	алды
14	Хамниган	nü’up	33	Якут	алта
15	Эвенк	нунй	34	Уйгур	алтэ
16	Эвен	нунци	35	Узбек	олти
17	Солон	нуну	36	Шар уйгур	алта-алтва
18	Негидал	нунй	37	Тофалар	alti

Монгол хэлний ‘jiryuyan’ нь ‘jir (ji-r) +yu+yan’, манж хэлний ‘ninggun’ нь ‘ni+ng+gun’ гэж тус тус гурван бүтээвэртэй аж. Олонхын хүлээн зөвшөөрдгөөр уг тооны нэрийн ерөнхий

⁶⁷ Хэдийгээр могол хэл нь Афганы газар нутгийн уугал хэл болох иран, перс, тажик, афган зэрэг хэл аялгууны нөлөөд хүчтэй орсон боловч, зарим нь сөнөж мөхөж буй хэл хэмээн үздэг ч, эрдэмтэн П. Поуха “Афганистан дахь могол хэл, холилдсон хэлний онол хоёр” сэдэвт илтгэлдээ могол хэлийг хольцолдсон хэлнүүдтэй нь авиан зүй, үгийн сан, өгүүлбэр зүйн төвшинд харшуулан судалж, “...Хэдийгээр могол хэл өөрийн харш хэлнүүдийн нөлөөд хүчтэй орсон боловч холимог хэл гэж үзэхгүй байх гэдэгт би итгэнэ” хэмээн дүгнэсэн буй.

бүтэц нь: хоёрын утгатай “*ji-(-r-)*” язгуур, гурвын утгатай “*yi-*” язгуур болон тооны нэр бүтээх “*-yan*” дагавар байна.

Орчин цагийн монгол хэлний “*хооронд*” гэх үгийг “*qoyur dumda ~ qoyur dunda*” хэмээн тогтвортой бичиж байснаас *хоор+дунд* хэмээх хоёр үг нийлж бүтсэнийг тодорхой харж чадах бөгөөд ийм бичлэгийг олж үзэхэд нэг их эрж хайхын ч хэрэггүй, элбэг тохиодог. Тэгвэл, эхнийх нь “*qoyur*” хэмээх үгийг цааш “*qo (хоёрын тоог эр хүйст илтгэсэн язгуур)+yi (гурвын тооны язгуур)+r (дагавар бүтээвэр)*” гэж задалж болохоор санагдана. Өөрөөр хэлбэл, энэ үг *ji-r+yi+yan*, *jiyur-a ~ jayur-a* гэсэн шиг үлгэр загвараар бүтсэн үг бололтой. Ац хагалах чадал мөхөстөн тээнэгэлзэх дүр байдлыг илтгэсэн “*хоёрын хооронд, гурвын дунд*” гэсэн хэллэгийг ч үүнд татаж болох юм.

Манж, монгол бичгийн хэлнээ үгийн эхний ‘*n~j*’ гийгүүлэгч сэлгэдэг зүй тогтлоор эхний гийгүүлэгчүүд сэлгэсэн байна. Авианы ийм тохироо бүхий үгс *mo. jiryu – ma. niruyan /зураг/, mo. jilyu-a – ma. niolqū /жолоо/, mo. jiyasu – ma. nimaha /загас/, mo. jiru – ma. niru /зура-/* зэргээр цөөнгүй тохиолддог. Энэ нь хоёр хэлний хооронд төдийгүй мөн дархадын аялгуунд, өвөрлөгчдийн зарим аялгуунд *зулгаа–нулгаа* гэхчлэн монгол хэлний нутгийн аялгуунд ч сэлгэдэг. Тиймээс *ninggun* гэдгийн “*ni*” нь монгол бичгийн хэлний *jirin, jici, jige, jirmüsüin* гэдэг үгст буй “*2*” гэсэн утга бүхий “*ji-*” язгууртай таарна.

Хасбаатар “*Монгол хэлний ‘-r-’, ‘-l-’ нь манж хэлний ‘-ngg-’-тэй тохиролцоно. Жишээ нь, jiryuyan – ninggun /зургаа/, jalgi – ninggu /залги-/’*. *kürge- unggi /илгээ-, хүргэ-/* Мөн монгол хэлний үгийн дундах *-q-, -y-, -g-* гийгүүлэгч манж хэлний адил байр дахь *-ngg-* тэй тохирдог гээд *mo. gegen – ma. genggiyen /гэгээн/, mo. cögen – ma. tongya /цөөн/, mo. cayan – ma. sanggiyan /цагаан/, mo. alay-a – ma. falangyi /гарын алга/* зэрэг үгээр жишээ татжээ.⁶⁷ Энэхүү авианы тохироогоор ‘*jiryuyan*’ ба ‘*ninggun*’-ий хоёрдугаар үеийг тайлбарлаж болно.

Өөрөөр хэлбэл, хэдий манж түнгүүс хэлний түүхэн харьцуулсан тольд дурдаагүй боловч, тус тооны нэрийн бүтцийг Г.И.Рамстедтийн ‘*jiryuyan*’-ыг гольд хэлний *ningun*, негидал хэлний *n’ingun*-тэй холбоотой⁶⁸ гэсний талд байгаа бөгөөд

**jiryuban* > *jiryuyan* [мо.] > *niryuyan* > *ningyun* > *ninggun* [ма.]

гэсэн хөгжлийн дүнд манж, монгол хэлний зургаагийн тооны нэр үүссэн гэж үзэж байна.

Mo. *doluyan* – Ma. *nadan*

1	Монгол	<i>doluyan</i>	19	Негидал	нада(н-)
2	Дагуур	долб(н) <i>doloo, dolo᠒᠒</i>	20	Ороч	надаја
3	Зүүн ёгор	долбн	21	Уд	нада(н-)
4	Баоань	дэлоң	22	Ульч	нада(н-)
5	Монгор	дэлбн	23	Орок	нада(н-)
6	Дунсян	дэлэн	24	Нанай	нада(н-)
			25	Турк	yedi

⁶⁷ Qasbayatur, *Mongyol. manju kelen-ü sudulul*, Öbür mongyol-un yeke surγayuli-yin keblel-tün qoriy-a, 1991, 55-56 –r tal-a.

⁶⁸ Г. И. Рамстедт, *Введение в алтайское языкознание (морфология)*, перевод с немецкого Л. С. Слоним, Москва, 1957, стр. 65.

7	Дунсян	дэлэн	27	Чуваш	šičĕ (šičĕĕ)
8	Дөрвөлжин бичиг	ᠳᠡᠯᠡᠨ	28	Тува	чеди
9	Монгол и и юй	朵蠻dolon	29	Хакас	чүтү
10	Хуа и юй	朵羅安dolo'an	30	Якут	сэттэ
11	Мукадимат, Ибн, Л.	dola:n	31	Азербайжан	yeddu
12	Ибн	dola'a:n	32	Башкир	ete
13	Халимаг	долан	33	Татар	жиде
14	Манж	nadan	34	Казак	жеті
15	Зөрчин	ᠳᠡᠯᠠᠨ nadan	35	Киргиз	жети
16	Хамниган	nadan	36	Уйгур	йете
17	Эвенк	надагда	37	Узбек	етти
18	Эвен	надалта	38	Тофалар	hsedi
19	Солон	надā			

Газар, газар доорх ертөнцийн бэлгэдэл, уруу чиглэсэн орон зайн босоо чигийн бэлгэдэл хэмээн үздэг⁶⁹ тус тооны нэр нь монгол хэлэнд ‘*dol-u-yan*’ гэсэн бүтэцтэй. Л. Лигети *tayusin* “*моос*”, хятан хэлний ‘*tawus*’ (*tcyusin /mooc/*) гэсэн үгийг нягталж, хоёрдугаар үеийн уруулын “о” эгшгийн нөлөөгөөр ухран ижилссэний дүнд эхэн үеийн “а” > “о” болдог нь эртний монгол хэлний нэг онцлог гэж үзжээ.⁷⁰ Энэхүү хэлний үзэгдэл орчин цагийн монгол хэлний “*долоо*” гэсэн үгэнд ажиглагддаг.

Иймээс ‘*doluyan*’ гэдгийн язгуур нь ‘*dal*’ байсан ба язгуур нь хятан хэлний ‘*dal*’ /*долоо-7/*, зөрчин хэлний ‘*dalxon*’ /*арван долоо-17/*, монгол хэлний ‘*dalan*’ /*дал-70/* зэрэгт уг хэвээрээ уламжилж, дундад үеийн монгол хэлний дурсгалуудад тэмдэглэгдсэн байдлаар язгуурын эгшиг хэдийн “о” болж, урт эгшгийн бүтэц дэх гийгүүлэгч сугарчээ. Эрдэмтэд тус тооны нэрийн язгуурын уг хэлбэр “*dal*” гэдэгт санал нэгтэй,⁷¹ утгыг Г. И. Рамстедт “*долоо-*” гэсэн үйл үгтэй⁷², М. Базаррагчаа “*олох долох*”-оос гарсан гээд түрэг төрлийн хэлнүүдэд долоогийн тоо нь “*ид-*” гэсэн утгатай “*уе-*”, үйлээс нэр бүтээх “*ti-*” дагавраас бүтсэнийг холбожээ.⁷³

Бид манж хэлний долоогийн тооны нэр “*nadan*”-ийг **daluyan* (<**daluban*)-аас үе тонгорон үүссэн, хөгжлийн хувьслыг нь:

(<**daluban*) > мо.**daluya:n* > *dolu':an* > *dolo'a:n* > *dola'a:n* > *dola:n* > *dolo:n*
> ма. **danuyan* > *naduyan* > *nadan*

гэсэн байдлаар үүссэн болов уу гэж үзэж байна.

⁶⁹ С. Дулам, Монгол бэлгэдэл зүй, I, *Тооны бэлгэдэл зүй*, Улаанбаатар, 1992, 2007, 126 –р тал;

⁷⁰ Louis Ligeti, *Le Tabghatch, un dialecte de la langue Sien-pi*, Mongolian Studies, Budapest, 1970, pp.265-308; Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний хөгжлийн эртний үе. түүнийг судалсан тойм*, Монгол Судлалын сонгомол өгүүлэлийн эрхи, I хэлмэли, Монгол хэл бичиг, II дэвтэр, Эртний монгол хэлний судлал, Улаанбаатар, 1999, 96-р тал.

⁷¹ N. Poppe, *The Groups *iya and *iige in Mongol Languages*, p.11; М. Базаррагчаа, *Монгол үгийн гарлыг мөшгих нь*, II, Улаанбаатар, 1992, 223-р тал; Г. И. Рамстедт, *Введение в алтайское языкознание*, Москва, 1957, стр.14-15; Д. Төмөртоогоо, *Монгол хэлний тооны нэрийн бүтэц, тогтолцоо*, (1980), Монгол хэл шинжилгээний онол, түүхийн асуудалууд, 2002, 240-р тал.

⁷² Г. И. Рамстедт, *Введение в алтайское языкознание*, Москва, 1957, стр.14-15.

⁷³ М. Базаррагчаа, *Монгол үгийн гарлыг мөшгих нь*, II, Улаанбаатар, 1992, 223-р тал.

'*doluyan*', '*nadan*'-аас гаралтай үгс:

Монгол хэлэнд:

doluy-a, doluyanta, doluyayad, doluyula, doluyayula, doluyaduyar, doluduyar, dolon (~*nayur-gazрын нэр*), *dalan, dalanta, dalayad, dalayula, daladuyar, doluy-a, doliya-, doliyabur doliyalу-a, dolyadasu, doluyadai, dolumayai, dolun-a, doluyun-a,*

манж хэлэнд:

nadan- *nadači* /долдугаар/, *nadata* /долоогоод/, *naihi* /долоон өвгөн од/

Мо. *naiman* – Ма. *jaqūn*

1	Монгол	<i>naiman</i>	16	Эвен	жапкй
2	Дагуур	найма(н)	17	Эвен	жапкыгъ
		<i>naiṃe, naimṃen</i>	18	Солон	жакку
3	Зүүн ёгор	наиман	19	Негидал	жапкун
4	Могол		20	Ороч	жаппу(н)
5	Баоань	німаң	21	Уд	жакпу(н)
6	Монгор	німаг	22	Ульч	жакпу(н)
7	Дунсян	німан	23	Орок	жакпу(н)
8	Дөрвөлжин бичиг	ᠨᠠᠮᠠᠨ <i>nayī ma na</i>	24	Нанай	жапка(н)
9	Монгол и и юй	奈蠻 <i>naiman</i>	25	Турк	<i>sekiz</i>
10	Хуа и юй	乃蠻 <i>naiman</i>	26	Чуваш	<i>sakār (sakkār)</i>
11	Мукадимаг, Ибн, Л.	<i>naiman</i>	27	Хакас	<i>sikeš</i>
12	Халимаг	нямн	28	Тува	<i>sehes</i>
13	Манж	<i>jaqūn</i>	29	Башкир	<i>higed</i>
14	Зөрчин	𐰽 <i>jakūn/dzakan</i>	30	Азербайжан	<i>sakkiz~sekkiz</i>
15	Хамниган	<i>jarkun zap</i>	31	Якут	<i>aγys</i>

Утга соёлын үүднээс газрын гадаргуу дээрх хавтгай чигийг заасан орон зайн бэлгэдэл, нарт ертөнцийн бэлгэдэл хэмээдэг⁷⁴ наймын тооны язгуурыг Г. И. Рамстедт **nayū*, Д. Төмөртогоо **nay* хэмээн үзсэн буй.⁷⁵

Хэдий монгол бичгийн хэлнээ өвөрмөц бичлэгтэй үг хэмээн, нэг шилбэтэйгээр *ᠨᠠᠮᠠᠨ* гэж бичиж хэвшсэн боловч уг нь **nayūman*, “-yū-” бүтээвэр нь “l”-ийн язгуурт “*ne+yū* -” гэж залгадгийн адилаар тооны нэрийн үндсэнд залгасан бүтээвэр. Тус бүтээврийн араас “*man*” бүтээвэр орохын тулд, өмнө нь анхандаа тооны нэрийн үндэс үүсгэх “-r-” бүтээвэр байгаад, хожим сугарсан байж болох юм. ‘*man*’ нь ‘*tūmen*’-д байдаг шиг тооны нэр бүтээх ‘*ban*’ дагаврын хувилбар. Хожим “*nayan*” нь дурдсан “-yū-” бүтээврийн “-yū-”-г хадгалж үлджээ. Монгол, манж хэлнээ “*n~j*” гийгүүлэгч сэлгэдэг зүй тогтол буй боловч тус хоёр хэлний наймын тоог гарал нэгтэй хэмээн шууд хэлэхэд бэрх аж.

'*naiman*', '*jaqūn*'-аас гаралтай үгс:

Монгол хэлэнд:

naiman, naimanta, naimayad, naimayula, naimalji, naimaljin, naimadaki, naimaduyar, naimača, namiljayan-a, namiljaryan-a, naya, nayanta, nayayad, nayayula

манж хэлэнд:

jaqūn /найм/, *jaqūnggeri* /наймантаа/, *jaqūta* /наймаад/, *jaqūci* /наймдугаар/, *jaqūri suje* /

⁷⁴ С. Дулам, Монгол бэлгэдэл зүй, I, *Тооны бэлгэдэл зүй*, Улаанбаатар, 2007, 126 –р тал.

⁷⁵ Д. Төмөртогоо, *Монгол хэлний тооны нэрийн бүтэц, тогтолцоо*, (1980), Монгол хэлшинжилэлийн онол түүхийн асуудалууд, Улаанбаатар, 2002, 241-р тал.

найман ширхэгт торго/, jaqūnju /ная/, jaqūnjuta /наяд/, jaqūnjiuci /наядугаар/

Mo. yisün – Ma. uyun

1	Монгол	yisün	17	Солон	jəgü
2	Дагуур	jicē(н) ise, isDen	18	Негидал	jəgin
3	Зүүн ёгор	icēn	18	Ороч	хуу(+)
4	Баоань	jəcōn	20	Уд	jəju
5	Монгор	шдзен	21	Ульч	хуу(+)
6	Дунсян	jəcун	22	Орок	хуу(+)
7	Дөрвөлжин бичиг	ᠡᠳᠦᠷᠪᠡᠯᠵᠢᠨ	23	Нанай	хуу
8	Монгол и и юй	曳孫 yisün	24	Турк	toquz
9	Хуа и юй	世孫 yesüne	25	Уйгур	toqoz
10	Мукадимат, Ибн, Л.	yisün	26	Чуваш	täxär (täxär)
11	Халимаг	йесен	27	Якут	toyuz
12	Манж	uyun	28	Хакас	toguz
13	Зөрчин	九 ujewun uyun	29	Башкир	toyid
14	Хамниган	yegin	30	Тува	tos
15	Эвенк	jəgin	31	Азербайжан	dogguz
16	Эвен	yун	32	Тофалар	toʻhis
			33	Татар	toqyz

Монгол түмэн зон олноороо есийн тоог мөнх хөх тэнгэрийнхээ тоон бэлгэ болгож, дээдийн дээд бэлгэшээл бүхэндээ есөн, түүний давтлыг шингээж ирсэн билээ. Тус тооны нэрийн язгуурыг Г. И. Рамстедт *jiz, *jüz, Д. Төмөртоогоо *jir-sü-n, О. Прицак *jir, *jer, М. Базаррагчаа *дирүсүн < дүрисүн < жирүсүн < ирүсүн < иисүн зэргээр үзжээ.⁷⁶

Долоогийн тооны язгуур *dal нь “dalan” -дбуй шиг, есийн язгуур *yer нь “yeren” -дагуулагдаж байгаа бөгөөд нэгчийн орны тооны нэрийн анхдагч хэлбэр нь уугал төрхөөрөө аравтын орны тооны нэрийн бүтцэд илүү хадгалагдаж үлдсэний бас нэгэн жишээ “yeren” болох юм. Хэрэв эл язгуурын бүтэц дэх “-r-” нь бусад нэгчийн орны тооны нэрд байгаачлан тооны нэрийн үндэс үүсгэх дагавар бүтээвэр гэвэл язгуурын талаар манжийн “uyun”, монголын “yisün” хоёр таарч буй. Буриадад ‘yühen’ гэдэг нь монгол, буриад хэлнээ ‘h-s’ гийгүүлэгч сэлгэдэг түгээмэл зүй тогтлоос болжээ. Ж. Төмөрцэрэн барга аялгууны тухай “... ‘i, i’ эгшиг уруулин ижилсэх, уужимшин ижилсэн зүйл олон тохиолдохоос гадна үгийн эхэнд хагас битүү үе болсон удаа ч тохиолдоно”⁷⁷ гээд жишээ үгсийн дотор “yühē” гэж “ec”-ийн тооны нэрийг оруулсан байдаг.

Манж хэлний есийн тоо нь хоёр болон дөрвийн тооныхтойгоо тун төстэй (*jurben > juben > juwen > juwe ; *durgin > dugin > duyin > duin) замаар *yergun -ээс “-r-” н сугарч, олонх нэгчийн орны тооны нэрийн дагавар “ban~bin” түүний хувилбар “gin” нь “y”-ийн нөлөөгөөр урагшлан “i” болж, хамниган, эвенк, солон, негидал зэрэг хэлнээ “yegin” болон хөгжиж, улмаар зөрчин хэлнээ “g” нь шүргэх гийгүүлэгч болон суларч “ujewun~ uyun” хэлбэрээр,

⁷⁶ G. J. Ramstedt, Über die Zahlwörter der Altaischen Sprachen, JSFOu, 24:1, 1907, S.17; Д. Төмөртоогоо, Монгол хэлний тооны нэрийн бүтэц, тогтолцоо, (1980), Монгол хэлшинжилэлийн онол түүхийн асуудалууд, Улаанбаатар, 2002, 241-р тал; О. Pritsak, Mongolisch yisün “neun” und yiren “neunzig” 8 s.243-245; М. Базаррагчаа, Монгол үгийн гарлыг мөшгих нь, II, Улаанбаатар, 1992, 210-р тал.

⁷⁷ Ж. Төмөрцэрэн, Баргын тухай товч тэмдэглэл, Хэл зохиол, Том. VIII, Fasc. 16, 210 дугаар тал.

улмаар манж хэлнээ “*ууин*” болж хувьссан гэж үзэж болохоор байна.

‘*yisün*’, ‘*ууин*’-ээс гаралтай үгс:

монгол хэлэнд:

yisü, *yisüi*, *yisün*, *yisüngke*, *yisünte*, *yisükei*, *yisügen*, *yisüle*, *yisülegül*-, *yisülegčün* (*есөн толгойт сүүлт амьтан*), *yisüde*-, *yisüdeki*, *yisüdüger*, *yere*, *yerente*, *yerentei*, *yereged*, *yeregüle*, *yeredüger*

манж хэлэнд:

ууин /*ес*/, *ууингге* /*ест*/, *ууинггер* /*есөнтөө*/, *ууите* / *есөөд* /, *ууиту жофохори* /*ест жүржэ*/, *ууулемби* /*есөлмүй*, *еснөө өлзийлмүй*/, *ууульту* /*есөгчин*/, *ууици* /*есдүгээр*/, *ууурсу тухерен* /*есөн гархи*/, *ууунжу* /*ер*/, *ууунжуге* /*ерээд*/, *ууунжуци* / *ердүгээр* /

Мо. arban – Ма. juwan

1 Монгол	arban	15 Хамниган	jân
2 Дагуур	арбāң ~ арwāң harebe, hareben	16 Эвенк	žân
3 Зүүн ёгор	харван	17 Эвен	žаппу
4 Баоань	harэн	18 Солон	žâ
5 Монгол	харан	19 Негидал	žâm
6 Дунсян	шы ⁷⁸	20 Ороч	žâ(+)
7 Дөрвөлжин бичиг	𠬪𠬮𠬰 harban	21 Уд	žâ(+)
8 Монгол и и юй	合魯班 haluban (harban)	22 Ульч	жуван
9 Хуа и юй	哈兒班harban	23 Орок	žôn
10 Zir. ⁷⁹	arban	24 Нанай	žoã
11 Мукадимат, Ибн, Л	harban	25 Түрэг төрлийн хэл ⁸⁰	оп
12 Халимаг	арвн	26 Чуваш	vun(ã) (vunpã)
13 Манж	juwan	27 Якут	uон
14 Зөрчин	𠬪 juwa	28 Татар	uп
		29 Башкир	uп

Монгол, манж хэлний арвын тоо нь бусад тооны нэртэй ижил гурамсан бүтэцтэй байна.

Үүнд: мо. *pa-r-ban > *ha-r-ban > a-r+ban

ма. *ju-(*)-ban > ju-wan

Д.Төмөртоогоо уг тооны нэрийн язгуурыг “эртний монгол хэлний тодорхойгүй олон тооны утга бүхий язгуур морфем байсан бололтой. Монгол хэлний бараг бүх тооны нэрийн нэгчийн орны язгуур, аравтын орны язгуур хоёр нь өөр хоорондоо тохирдог атал нэг, арав 2-ын язгуур тохирохгүй байгаа нь анхаарал татаж байна”⁸¹ хэмээжээ. Г. И. Рамстедт, М. Базаррагчаа нар *арвайх*, *сарвайх* зэрэг дүрслэх үйл үгээс үүссэн гэсэн буй.⁸² Тенишев

⁷⁸ Дунсян хэлэнд арваас дээш тооны нэрд хятад үг хэрэглэдэг.

⁷⁹ Д. Төмөртоогоо, Араб үсэгийн монгол дурасгалын судалгаа, Улаанбаатар, 2002.

⁸⁰ Азербайжан, казак, уйгур, киргиз, тува, тофалар, хакас гэхчлэн түрэг төрлийн хэлний бараг цөмд адил тул ийн оруулж, үүнээс авианы талаар бага зэргийн өөрийг нь хүснэгтэд оруулав.

⁸¹ Д. Төмөртоогоо, *Монгол хэлний тооны нэрийн бүтэц, тогтолцоо*, (1980), Монгол хэл шинжилгэлийн онол, түүхийн асуудалууд, 2002, 242-р тал.

⁸² Г. И. Рамстедт, *Введение в алтайское языкознание*, Москва, 1957, стр. 66; М. Базаррагчаа, Монгол үгийн гарлыг мөшгих нь, II, Улаанбаатар, 1992, 214-р тал.

түрэгийн “*on*” *баруун гар* гэсэн утгатай байсан гэжээ.⁸³

Энэ мэт утгын нийтлэг байдлаас үзвэл, манжийн “*juwan*”-ы “*ju*” язгуур нь *зуурах* гэсэн утгатай *juuempri*, *juuekebi* зэрэг үгсийн язгуур байж болох юм. Эдгээр тоо нь цааших тооны нэрийн бүтцэд уламжлахдаа түрэг, монгол хэлнийх нь бүхлээрээ шингэсэн бол, манж хэлний “*juwan*”-ы “*ju*” язгуур нь утгаа уламжлан тээжээ.

Ер нь монгол хэлний “*qoyar*”-оос бусад тооны нэр ‘-*n*’ төгсгөлтэй аж. Ойролцоо утгат хоёр язгуур нийлж бүтсэн ‘2’ (‘*qo+jir*’)-ын ‘*jir*’ нь дангаараа хэлний нэрлэх дохио болохгүй, холбох бүтээвэр ‘-*r*’, нэр үндэс үүсгэх ‘-*n*’ бүтээвэр авснаар ‘*jirin*’ болж сая тооны нэр болдог билээ. Иймд, ‘*qoyar*’ гэсэн үг нь уг гарал бүтцээрээ монгол хэлний тооны нэрийн үндэс үүссэн зүй тогтлоос гажсан зүйлгүй юм. “*Монголын нууц товчоон*”-ы хэлэнд үндсэн тооны нэр нь тийн ялгалаар хувирахдаа эцсийн ‘*n*’-ээ тогтвортой хадгалсан байдаг. Гэтэл “*Ляо улсын судар*”-т хятан хэлний ‘*taw*’ (*тав*), ‘*jau*’ (*зуу*) хэмээх үгийг ‘*n*’-гүй тэмдэглэжээ. Үүний учир нь, хятан хэл бол монгол бичгийн хэл хийгээд “*Монголын нууц товчоон*”-ы хэлний суурь болсон аялгуунаас нэлээд өвөрмөц, тэр цагийн монгол хэлтний өмнөд салбарын нэгэн аялгуунд суурилсанд байгаа болов уу. Манж хэлний нэгчийн орны тооноос ‘*sunja*’, ‘*juwe*’-ээс бусад нь ‘*n*’-тэй бөгөөд ‘*juwe*’ нь утгаа ‘*n*’-тэй байсан гэж үзэх үндэс бий. Монгол, манж хэлний нэгчийн орны тооны нэрийн тухайд бид *нэг, хоёр, дөрөв, тав, зургаа, долоо, есийн* тоонууд гарал нэгтэй хэмээн үзэж байна.

II. Арван нэгээс арван ес хүртэлх тооны нэр

Тоо	Монгол	Манж
11	arban nigen (~arban nige)	juwan emu /omšon/
12	arban qoyar	juwan juwe /joryon/
13	arban yurban (~arban yurba)	juwan ilan
14	arban dörben (~arban dörbe)	juwan duin
15	arban tabun (~arban tabu)	tofohon
16	arban jiryuyan (~arban jiryuy-a)	juwan ninggun
17	arban doluyan (~arban doluy-a)	juwan nadan
18	arban naiman (~arban naima)	juwan jaqūn
19	atban yisün (~arban yisü)	juwan uyun

Манж, монгол хэлний аль алинд аравтын орны тооны үндсэн бүтэц нь: “*аравтын орны нэр + үндсэн тооны нэр*” юм. Харин тогтолцооноос гажууд хэлбэрээрээ зайлшгүй анхаарал татахуйц нь манжийн зөвхөн 11, 12 дугаар сарыг заахдаа тухайлан хэрэглэдэг “*omšon*, *joryon*” болон 15-ын тоог аливаа бүхэнд илэрхийлдэг “*tofohon*” гэсэн үгсийн содон төрх болно. Ихэвчлэн “*joryon*” гэж тогтвортой бичдэг ч “*jorhon*” гэсэн хэлбэрээр тохиолдох нь бас бий. Жишээ нь:

elhe taifin i orin sunjači aniya, aniya biyači deribume jorhon biyade

⁸³ Л. Болд, *Түрэг, монгол хэлний тооны нэр*, Улаанбаатар, 2005, 27-р тал.

iki jagirmi /хоёр+хорь/ нь 12-ыг

йц jagirmi /гурван+хорь/ нь 13-ыг тус тус илэрхийлдэг.

Энэтхэг европын хэлнүүдэд ч *thirteen, fourteen, fifteen, sixteen, seventeen, eighteen, nineteen* гэх мэтээр хэлдэг тул тогтолцооны ийм хэв маягийг нэг талаас нийтлэг ч гэж хэлж болно.

Өгүүлсэн тогтолцоонд шулуухан холбогдох баримт “*Алтан улсын судар*”, “*Нишан удганы бичиг*” зэрэг бичгийн дурсгалд тохиолдож байгааг эш татвал:

“*Алтан улсын судар*”-т “...*wan yan i niyalma, siyan pu i baru hendume, si meni jalinde ere kimun be naqabume juwe tuqin be ishunde wamuraqi obuha de, mende emu sain saryan jui bi, ninju se otolo eigen yaijara unde, sinde bure, muse emu aiman oki...*”⁸⁴ (үгчлэн орчуулбал, ...*Вань Яний хүмүүн, Сянь Пү-гийн зүг өгүүрүүн, Чи манай тулд энэ өшөөг болиулан хоёр төрлийг харилцан алагдахгүй болгосонд, манд нэгэн сайн охин буй, жаран нас болтол нөхөр аваагүй, чамд өгсү, бид нэгэн аймаг болсу...*

Э. М.) гэсэн буй.

“*Алтан улсын судар*”-ын орос орчуулгад “... *Отсюда-то произошла пеня в тридцать лошадей и тридцать коров, платимая в княжестве Нюй-чжи по учению кем-либо убийства. Из колена ваньянь в благодарность Сяньпу прислали одну светло-бурую корову и шестидесятилетнюю девуцу. Тогда Сяньпу отдал обратно светло-бурую корову вместе вена, а шестидесятилетнюю девуцу взял себе в жены, получив все ее пахотные земли и другое имение. ...*” хэмээн орчуулжээ.⁸⁵

Хэрэв үүнийг үймээн самууныг түвшитгэн зассан “*тэнгэрээс заяат*” хөвүүнд **жаран настай** эрд гарч байгаагүй охиноо өгсөн гэвэл амьдралын бодит байдлаас хэтэрхий давуудах юм. Учир шалтгааны үүднээс эргэцүүлж, зөрчин нарын тооны бүтцийн талаарх мэдлэгт түшвэл, тус зохиолд гарч буй манж хэлний “60” (*ninju*)-тай хэлбэрийн хувьд яв цав нийлж буй “*ninju*” нь “6” /*ninggun*/-ийн тооны “*nin*” язгуур, “10” /*juwan*/-ын тооны “*ju*” язгуураас бүтсэн байгааг ойлгож болно. Тэгэхлээр 6+10 гэж бүтсэн тооны нэрийг зөрчиний аравтын орны тооны “*үндсэн тооны нэр+аравтын орны нэр*” гэсэн бүтцээр ухвал, 60 бус 16 болох нь. Уг язгуур сайт, нас залуу цус шинээн охин үрээ улс гэрийн төлөөнөө харийн газар бэрлүүлэн өгдөг ёс хүн төрөлхтний түүхнээ захаас аван бий.

Мөн манж нарын хэл, соёл, утга зохиол, шүтлэгийн үнэт сурвалж болох “*Нишан удганы бичиг*” –ийн зарим хувилбарт⁸⁶

“*nišan saman hendume, meni yašan de tehe nadanju sede ujihe emu nara fiyangyū bihebi. ere niyalma cingqai dahalara be dahame yemčen geyen (yeken) jergi de gemu ureshūn gese ere niyalma jici yargiyan i joboraqi šašun (hiyoošun) ijishūn bihe... nišan saman sabufi injeme hendume, wečeku de hūsun bure wesihun agu jiheu endu de aisilara erdemu*

⁸⁴ Я. Шаарийбуу, *Манжийн утга зохиолын дээж*, Улаанбаатар, 1999, 34-р тал.

⁸⁵ *История золотой империи*, Ответственный редактор В. Е. Ларичев, Новосибирск, 1998, стр. 89.

⁸⁶ Жиованни Старигийн судалгаанд орсон гурван эх болох “*Badarangya doro-i gosin ilaci aniya boji bidhe, Nizan z'ame bidhe*”, “*Yasen sama-i bidhe emu debtelin, decin-i bidhe inu*”, “*Niz'an saman-i bidhe jai debtelin, Li Tu Šan*” (Giovanni Stary, *Three unedited manuscripts of The Manchu epic tale <<Nišan saman-i bidhe>>*, Otto Harrassowitz, Wiesbaden, 1985) -д дурдан буй өгүүлэмж байхгүй.

*isibume mongyoso amban benjihe jaqa be salibuḟi šangnaha dangse.*⁸⁷

Лавшруулан үзэхүл үүнд, Б. Лауфер, Р. А. Миллер нарын анхлан шинжилсэн зөрчиний арван нэгээс арван ес хүртэлх тооны нэр⁸⁸ нь бусад төрөл хэлнийхээсээ өвөрмөц онцлогтой байдгийг анхаарах хэрэгтэй бөгөөд тэр нь дараах байдалтай:

- 11 – 七 amšo < amšon < *amuson ~ *amuhon = әmu + hon
- 12 – 尔 jirhon = jir+hon = A.Мо. *ji+r+hon
- 13 – 𠵹 gorhon = gor + hon = A.Мо. *gu+r+hon
- 14 - ... durhon = gor + hon = A.Мо. *dü+r+hon
- 15 - 五 tobohon = tobu +hon = A.Мо. *tabu+hon
- 16 – 丩 nilhun /nirhun/ = nir+hon < A.Мо. *jir+hon
- 17 – 土 darhon = dar + hon = A.Мо. < dal+hon
- 18 – 方 niyuhun = A.Мо. *nai+hon
- 19 - 尤 oniyohon = J. uyun +hon⁹⁰

Эндээс зөрчин хэл 11-19 хүртэлх тоог илэрхийлэх тусгай үгтэй, монгол болон манж хэлнийх нь нийлмэл бүтэцтэй боловч манж хэлэнд зөрчиний 'tofohon' /арван тав/, 'omšon' /арван нэг/, 'jorḟon' /арван хоёр/ уламжлан шингэсэн нь тодорхой байна.

Зөрчиний эдгээр тооны язгуур нь нэгчийн орныг, 'hon' нь аравтын орны утгыг гарцаагүй зааж байгаа тул бид өмнөх эрдэмтдийн саналын дагуу⁹¹ 'hon-on' нь одоогийн түрэг хэлэнд хадгалагдан үлдсэн, алтай хэлний дундын үг байгаад бүтээвэр болсон тооны нэр бүтээх дагавар гэж үзэж байна.

Өөрөөр хэлбэл, түрэг, манж-түнгүс, монгол төрөл хэлнүүдийн тооллын тогтолцоо нь арван хуруугаар тоолж эхэлснээс эхтэй атал 11-19 –ийн тоог нэрлэх нь одоогийнхоос урвуу бүтэцтэй чанарын ялгаатай аж. Эртний түрэг хэлний дурсгалд эдгээр тоог “нэгчийн орны тооны нэр + дараагийн аравтын орны тооны нэр” гэсэн нийлэмжээр илтгэсэн байдаг. Тухайлбал,

⁸⁷ Dayicing gürün-ü dotuḟadu yamun-u Mongḟol bičig-ün ger-ün dangsa, tabuduyar boti, Öbür mongḟol-un arad-un keblel-ün qoriy-a. 2005, pp.96.

⁸⁸ B. Laufer, *Jurčī and Mongol numerals*, KcsA 1:2 (1921), pp.112-115; Roy Andrew Miller, *Notes on the Jürchen numerals for the teens*, UAJb 47 (1975), pp.146-153.

⁸⁹ Зөрчин ханзад 金啓祿, 女真文辞典, 北京, 1984. -ийг эш болгов.

⁹⁰ Nicolas Poppe, *Jurchen and Mongolian*, Монгол судлалын сонгомол өгүүллийн эрих, I хэлмэли: Монгол хэл бичиг, II дэвтэр, *Эртний Монгол хэлний судлал*, Улаанбаатар, 1999, 34-р тал; Зөрчин ханзыг 金啓祿, 女真文辞典, 北京, 1984 –өөс эшлэв.

⁹¹ N. Poppe, *Ancient Mongolian*, In *Tractata Altaica*, Denis Sinor sexafenario optime de rebus altaicis merito dedicata, Redigerunt Walter Heissig, John R. Krueger, Felix J. Oinas, Edmond Schütz, Wiesbaden, 1976, pp. 464-478, Монгол судлалын сонгомол өгүүллийн эрих, I хэлмэли: Монгол хэл бичиг, II дэвтэр, *Эртний Монгол хэлний судлал*, Улаанбаатар, 1999, 7-22 -р тал; Nicolas Poppe, *Jurchen and Mongolian*, In *Studies on Mongolica*, by G. Schwarz, *Studies on East Asia*, Vol. 13, Western Washington University, 1979, pp. 30-37, Монгол судлалын сонгомол өгүүллийн эрих, I хэлмэли: монгол хэл бичиг, II дэвтэр, *Эртний Монгол хэлний судлал*, Улаанбаатар, 1999, 29-40 -р тал; Dr. W. Grube, *Die Sprache und Schrift der Jučen*. Leipzig, 1896; B. Laufer, *Jurčī and Mongol numerals*, KcsA 1:2, 1921, pp.112-115, Roy Andrew Miller, *Notes on the Jürchen numerals for the teens*, UAJb 47, 1975, pp.146-153; Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм*, Монгол судлалын сонгомол өгүүллийн эрих, I хэлмэли: Монгол хэл бичиг, II дэвтэр, *Эртний Монгол хэлний судлал*, Улаанбаатар, 1999, (67-126 -р тал), 110 –р тал.

нэрийг дурдвал:

dzsur. jirhon /12/ - kit. jir /2/	dzsur. gorhon /13/ - kit. gor/ur /3/
dzsur. durhun /14/ - kit. dur /4/	dzsur. tobhon /15/ - kit. taw /5/
dzsur. nirhun /16/ - kit. nir/nur /6/	dzsur. dalhon /17/ - kit. dal /7/

Христийн тооллын 905-1125 онд хойд Хятадад ноёрхлоо тогтоож “Ляо улс” хэмээн алдаршсан хятан нарын хэл дундад монгол хэлний өмнөд аялгуунд багтдаг билээ. Ингэхээр зөрчин нар монгол тооны нэрийг авсан нь тодорхой болно. Чухам яагаад зөрчин нар монгол тоог хэрэглэх болов? Тухайн үедээ мандан бадарч хүчирхэгжин тэлж байгаа улсаа жижиг буурай нь тойрон хүрээлдэг жамтай билээ. Тиймээс монгол угсаатны улс төр, утга соёлын нөлөө ялангуяа Ляо улсын үеэс зөрчин нарын дунд хүчтэй дэлгэрсний улмаас монгол тоог хэрэглэх болсон биз ээ. Харин монгол бичгийн хэлний дурсгалд аравтын орны тооны нэр ийм хэлбэрээр үзэгддэггүйн учир хятан хэл бол монгол бичгийн хэлний суурь болсон аялгуунаас нэлээд ялгаатайд орших болов уу.

III. Хориос дээших тооны нэр

Нийгмийн шаардлагаар арван хуруунаас цааш тоолох хэрэгцээ гарахад хоёр арав, гурван арав гэх мэтээр тоолж байв. Энэ нь олонгуяа эвенкэд *juur jaar* (хоёр арав)⁹², одоогийн Афганистаны могол хэлэнд ‘*yurban arban*’ /30/, ‘*qoyar qori*’ /40/, гэхчлэн хадгалагдаж үлджээ.

№	Тооны нэр	20	30	40	50
	Төрөл хэлнүүд				
1	Монгол	qorin	γučin	döčin	tabin
2	Дагуур	хорй(н) hori, horin	γu'ч'γ(н) gocí, gocin	дү'ч'γ(н) dücü, ducín	t'awĩ(н) tabi, tabin
3	Халимаг	хөөрэ	гуччу	дөчөө	тэвэ
4	Зүүн ёгор	хорен	үүчен	дөчен	тавен
6	Монгор	хорин	ходжин	тэджин	тајин
7	Баоань	хороң	ъобаран	дэрэраң	таваран
8	Монгол и и юй	忽魯 qulu (quru)	兀眞 γujin	獨噴 düčín	答賓 dabin
9	Хуа и и юй	豁舌鄰 qorin	中忽噴 qučín	朵噴 döčín	塔賓 tabin
10	араб	qorin	γučin	döčin	tabin
11	Манж	orin	γúsin	dehi	susai
12	Зөрчин	orin 彡	guřin gúsin 久	dehi 彡	susai 彡
13	Эвенк	орилугда	гутин	-	тунцаžан
14	Хамниган	орин	гутин	дэгиннье	тунгманнье
15	Солон	орй	готй		сүсаи
16	Эвен	оривугда	гутин~гучин		
17	Негидал	ojun			

⁹² Toshiro Tsumagari, *A Basic vocabulary of Khamnigan and Oluguya Ewenki in Northern Inner Mongolia*, Bulletin of the Institute for the Study of North Eurasian Culture, Hokkaido University, №21, 1992, pp.83-103

19	Ороч	он<*ojun<orin	гути(н-)	
20	Уд	ваји-уан<*ojвп<orin		
21	Ульч	хори(н-)	гүти(н-)	сусај
22	Орок	хори(н-)		
23	Нанай	хорй̄	гочй̄	сосай-сосај

	60	70	80	90	100
Монгол	jigan	dalan	науан	yeren	јагун
Дагуур	арй̄(н) jagi, jagDen	далй̄(н) dale, dalDen	најй̄(н) nai, naiDen	јүрй̄(н) ire, irDen	цай̄ jau, jaDen
Халимаг	жиирэ	даалы	наайы	йээрэ	зу
Зүүн ёгор	джіган	далан	најан	јірэн	tumen
Монгол	джіран	далан	најан	јірін	tumun
Баоань	джірџораң	доларан	німараң	јэсаран	
Монгол и и юй	只刺 jila (jira)	答刺 dala	乃彦 naiyan	也連 yelen	介 jau
Хуа и и юй	只舌關 jigan	答關 dalan	乃顏 naiyan	也舌连 yeren	札温 ja'un ja'u:n
Араб үсгийн дурсгал	jigan	dalan	науан	yiren	jawu:n tangyu
Манж	ninju	nadanju	jaqunju	uunju	
Зөрчин		nadanju ㄣ	jakunju ㄨ	ujewunju uunju	tanggu ㄣ
Эвенк	н'унунз̄ан	наданз̄ан	запкунз̄ан	јэүунз̄ан	па'man
Хамниган	нунгуннье	наданнье	джапкуннье	йегиннье	панаaji
Солон	нуңурнй̄	надарнй̄	заккүрнй̄	уйн'уу'н	намāзи
Эвен	н'унън ма̄р	надън ма̄р	запкун ма̄р	ујунмер	тангу на'на
Негидал	н'унунз̄ан		запкунз̄ан	јэүинз̄ан	н'ама~н'аму
Ороч	н'унунз̄а	наданз̄а	запунз̄а	хујунз̄а	тангу тангу
Уд	н'унуз̄э		запунз̄а	јэјиз̄э	тангу
Ульч		наданз̄у	запунз̄у	хујунз̄у	тангу
Орок	н'унгунд̄о	наданд̄о		хујундо	тангу
Нанай	н'унгунг̄у	надајнгу	запюјнго	хујунгу	тангуо'у

Г. И. Рамстедт “Түрэг хэлний ‘on/an’ /арав/ нь эдгээр хэлнүүдийн хамтын хуучин бүтээвэр байж мэднэ. Турк хэлний ‘on’ нь ‘seksen’ /80/, ‘toqsan’ /90/ гэх үгэнд бүтээвэр болж байх бөгөөд монгол хэлний ‘jigan, dalan, науан, yeren’ гэх үгэнд залгавар болж буй”⁹⁷ гэжээ. Харин Өвөр монголын судлаач Бөх “монгол хэлний аравтын орны тоог нэгчийн орны тооны нэрийн үндсэнд ‘on/ an/ en’ гэх бүтээвэр залгаж бүтэжээ гэхэд баахан асуудалтай шиг байна. Учир нь монгол хэлэнд ‘an/ en’-ээр төгссөн үг аравтын оронд төдийгүй yurban, dörben, doluyan гэх зэрэг нэгчийн орны тоонд ч буй” гэжээ.⁹⁸ Энд хэлсэн нэгчийн орны тооны нэрийн бүтэц буй “-an, -en” бол тооны нэр бүтээх дагаврын бүрэлдэхүүн гэдэг нь тодорхой.

Монгол хэлний хориос дээших тооны нэрийн бүтэц нь нэгчийн орны тооны нэрийн язгуур дээр арвын утгатай ‘on’, түүний хувилбар ‘an/en/in’-ийг залгасан байдалтайгаар ‘qorin, yicin,

⁹⁷ Г. И. Рамстедт, *Введение в алтайское языкознание*, Москва, 1957, срт. 66.

⁹⁸ Бөх, *Монгол төрөл хэлнүүдийн тооны нэрийн зарим асуудал*, ӨМИС, Эрдэм шинжилгээний бичиг, I, Хөххот, 1988.

döčin, tabin, jiran, dalan, nayan, yeren гэж бүтсэн болов уу. ХТ 386-538 онд хойд Хятадад ноёлж байсан, Тоба, Табгач нэрээр алдаршсан Сяньби нарын хэлэнд гучийг 'hošen' гэдэг байв. Түрэг төрөл хэлний нэг баруун ёгор хэлэнд аравтын тоо нь:

diort /4/ + on /10/ > diordon /40/

bes /5/ + on /10/ > beson /50/

ahid /6/ + on /10/ > ahidon /60/

jid /7/ + on /10/ > jidon /70/ гэсэн бүтэцтэй.

Манж хэлний '*orin*' /20/, '*yūsin*' /30/ нь '*on*'-ы хувилбар '*in*'-ийг агуулсан байдалтай байх бөгөөд эндээс монгол, манж хэлний хоёр, гурвын тоо ялгаатай атлаа хорь, гуч нь бараг адил байхын учир юу вэ? гэсэн асуудал гарна.

Тоо:

2

20

3

30

Монгол хэлэнд:

qoyar / jirin

qorin

yurban

yüčin

Манж хэлэнд:

juwe

orin

ilan

yūsin

Mo. qorin – Ma. orin: Эртний монгол хэлний эгшгийн өмнөх чанга хамжих *q гийгүүлэгч дэд үеийн сул гийгүүлэгч 'r'-ийн нөлөөгөөр хамжих үйлдлээ алдаж, 'h' болоод орчин цагийн монгол хэлэнд хамжин шүргэх "x" болон хөгжсөн бол улмаар манж түнгүсийн хэлэнд сугарч гээгдсэний дүнд эртний монгол хэлний *qorin нь horin болоод, зөрчинд worin~orin, манж, түнгүсийн хэлэнд orin болжээ. Ийм авианы тохироо бүхий үгсээс гэвэл:

мо. kögö- ~ ма. ого-

мо. küliye- ~ ма. aliya-

мо. körög ~ ма. üren г.м.

Mo. yüčin – Ma. yūsin: Эртний монгол хэлний "i/i" эгшгийн өмнөх "t" гийгүүлэгч "t"-ийн нөлөөгөөр дундад үеийн монгол хэл болон орчин цагийн олон монгол хэлэнд "č" болон хөгжиж ирсэн билээ. Харин эвенк, солон зэрэг түнгүсийн хэлнүүд дэх ормол үгс нь адил байр дахь "t" гийгүүлэгчээ хадгалсаар байна. Эндээс үзвэл "хорь, гуч" гэсэн тооны нэр монголоос манж хэлэнд оржээ. Монгол, манж хэлний "č" болон "s" харилцан тохирох зүй тогтолтой бөгөөд ийм хэдэн жишээ:

мо. či ~ ма. si

мо. čidür ~ ма. sideri

мо. küčün ~ ма. hūsun

мо. čiči ~ ма. seči-

мо. sibar ~ ма. čifahan

мо. sinjile- ~ ма. činčile-

Mo. döčin – Ma. dehi:

Монгол хэлний 40-өөс *dö-či-in*, манж хэлнийхээс *de-hi-in* гэсэн бүтцийг харж болно. "dö-, de-" бол дөрвийн тооны цөм утгыг илтгэсэн язгуур бүтээвэр, "in" нь аравтын орны тооны нэр үүсгэх дагавар бүтээвэр а

ж. Манжийн "-hi-" нь дөрвийн тооны үндэс үүсгэх бүтээвэр гэвэл, монголын "-či-" –г хэрхэн үзэх вэ? гэдэг асуудал гарч ирнэ. Бидний бодлоор, "yüči, döči" нь өмнө дурдсан уйгур, түрэг хэлээр 'ati', монголоор "ач" гэдэг "a" язгуур дээр 'či' дагавар залгасан үг бүтэх загвартай тохирох мэт санагдана. Үүнээс "yüčin" нь гуравдугаар арав, "döčin" нь дөрөвдүгээр арав гэсэн утгатай болж болох.

Mo. tabin – Ma. susai:

Монгол хэлний "50" нь бусад аравтын орны тооны нэрийн жишгээр "таван арав" гэсэн бүтэцтэй байна. Харин манжийн "тавь"-ийн бүтэц өвөрмөц агаад энэ удаад ямар нэгэн таамаглал дэвшүүлэхдээ гартлаа.

Mo. jiran, dalan, nayan, yeren – Ma. ninju, dalan, nayan, yeren:

Манж хэлний '60 - 90' -ийн тоо “*ninju, nadanju, jaqūnju, uyunju*” нь нэгчийн орны тооны нэрийн язгуур + уг хэлнийхээ арав гэх тооны нэр *'juwan'*-ы язгуур *'ju'*-г залгаж бүтжээ. Монгол хэлний *'qorin, yučin, dōčin'* гэх мэтийн *'in / an / en'* нь “арав” гэсэн утгатай гэвэл монгол, манж хэлний аравтын тооны нэр нь язгуур дээр арав гэх утгатай бүтээвэр залгаж бүтсэн адил тогтолцоотой байна.

ма. 'nin+ju'	/6+10/	мо. jir+an
ма. 'nadan+ju'	/7+10/	мо. dal+an
ма. 'jaqūn+ju'	/8+10/	мо. nay(i)+an
ма. 'uyun+ju'	/9+10/	мо. yer+en

Ийн үзэхэд, монгол, манж хэлнээ өмнө өгүүлсэнчлэн гарлын холбоотой “6”-ийн тоо мо. *jirγuyan*, ма. *nunggun* нь 2+3 гэсэн бүтэцтэйгээр бодвол, аравтын орны тоог илтгэсэн “мо. *jiran* ~ ма. *ninju*” нь 6+10 бус 2+10 гэж ойлгогдохоор буйг арваас цааш тоолох хэрэгцээ гарах үед “6”-ийн цөм утга “*ji-ni*” язгуурт нэгэнт шингэсэн байсан гэж тайлбарлаж болох юм.

Японы хойд нутаг, Сахалин, Курилийн арлуудаар нутаглаж байсан Аину нарын хэлэнд арвыг *'wan'* гэдэг нь мо. **parwan<arban*, ма. *juwan* –тай холбогдох бөгөөд ламут хэлний *'tan'* зэрэг нь *'b~w~m'* сэлгэсэн хувилбар юм. Түрэг хэлний *'on'*, эртний түргийн *'hon'*, ламутын *'tan'*, айнугийн *'wan'*, монголын *'harban'*, манжийн *'juwan'* зэргээс харьцуулахад “арав” гэсэн утгатай *'on'* нь нийт алтай хэлний дундын үг байсан гэж үзвэл зохилтой.

Mo. jayun – Ma. tangyū

Монгол хэлний 'y' гийгүүлэгч манж хэлний 'ng'-тэй тохирдог. Энэ ёсоор монгол хэлний *'jayun'* /100/, манж хэлний *'tangyū'* /100/-ын хоёрдугаар үе мо. *gegen* - ма. *genggiyen*, мо. *šayan* - ма. *šanggiyan* гэх мэт үгсийн адил таарч байна. **tangyūn < ma. tangyū, *tangyūn ~ *dangyūn > *dayūn >* Монгол хэлний 100-гийн улирч ирсэн хөгжлийн үе шат нь **jayūn > jayu:n > jawu:n > ja'u:n > jo'u:n > ju'u:n > dzu:n / zu:n* болох аж. Тус тооны нэрийн бүтээвэр нь үндсэн тооны нэр үүсгэх “*γan*” дагаврын хувилбар байх боломжтой.

Mo. mingyan, tümen – Ma. mingyan, tumen

Монгол, манж хэлний *'mingyan, tümen'* нь ямарваа нэгэн зөрөөгүйгээр шууд тохирдог. Үүнд ч мөнөөх тооны нэр бүтээх “*γan, tan*” дагавар оролцжээ. Хятадын 萬 (*wan*)-ий дуудлагыг сэргээн тэнхрүүлэхэд, “... ван биш, тман байсан гэж магадлан олсон нь, монгол түрэг хэлтний түмэн гэдэг нь нангиад хэлнээ ороод, дуудлага нь сунжирсаар, нангиад хэлнээ одоо ван болж, нангиадаас үсэг уламжилсан Японд бан болж ирсэн байнам.”⁹⁹ хэмээн академич Б. Ринчен гуай өгүүлсэн ба “десять тысяч” гэдгийн махчилсан орчуулга¹⁰⁰ бидний аманд арван мянга хэмээн орж хэвшсэн нь орос хэл, соёл суртал эрчимтэйгээр нэвчсэн саяхны үеэс болохыг тэмдэглэсэн буй.

Нэгтгэн дүгнэвэл, бид манж, монгол хоёр хэлний нэгчийн орны нэг, хоёр, дөрөв, гурав, тав,

⁹⁹ Б. Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, Гутгаар дэвтэр, Хэлбэр судлал, Улаанбаатар, 1966, 2007, 58-р тал.

¹⁰⁰ Б. Ринчен, *Монгол ард улсын хамниган аялгуу*, Улаанбаатар, 1969, 52-р тал.

зургаа. долоо, есийн тоонууд гарал нэгтэй буюу дундын бөгөөд тооны нэрс нь

a. язгуур + “ban” бүтээвэр (тэдгээрийн хувилбарууд)

b. язгуур + “r” бүтээвэр + “ban” бүтээвэр (тэдгээрийн хувилбарууд)

гэсэн, аравтын орны тооны нэрийн бүтэц нь:

нэгчийн орны тооны нэр+сравтын орны утгатай бүтээвэр

гэсэн ерөнхий ижил бүтэцтэй хэмээн үзэж байна.

Бид нэгийн тооны нэрийн нэн эртний хэлбэрийг ‘*niben*’ байсан болов уу хэмээн үзэж байгаагаа өмнө нэгэнтээ дурдсан билээ. Тэгвэл бусад тооны нэрийн бүтсэн байдал болох *язгуур + r бүтээвэр + yan бүтээвэр* гэсэн бүтцийн тогтолцоогоор ижилтгэн үзвэл, нэгийн тооны нэн эртний хэлбэрийг **nirben* хэмээн ахиулан сэргээж болох талтай. Үүнд түрэг төрлийн хэлний “*bir*” ч мөн хамаарч болох мэт.

Манж, монгол хэлний тооны нэр алтай хэлний дотор илүү ойр дөхүү бөгөөд үндсэн тооны нэрийн ихэнх хувь нь тохирч байна. Үүний нэг хэсэг нь гарал нэгтэй буюу дундын язгуур бүтээвэр бүхий, *orin* /хорь/, *yūsin* /гуч/, зөрчиний 11-19 –ийн тоо гэх мэт нэг хэсэгт нь харилцан нөлөөллийн үр дүн ч байх аж.

Мөн түмээс дээш цаглашгүй хүртэлх тооны зүйлд манж нар самгардаас уламжилсан төвд тооны нэрийг хэрэглэж байсан нь монголоор дамжсан нь дамжиггүй бөгөөд манж-түнгүс угсаатанд монголчуудын соёл ихээр нэвтэрч байсны бас нэгэн тод илрэл юм.

Алтайн онолын эсрэг байр суурьтай эрдэмтэд энэ овогт багтах хэлнүүдийнх нь тооны нэрс өөр зуураа таарахгүй гэсэн зүйлийг үзэл баримтлалынхаа нэгэн түшиц болгодог. Монгол, манж хэлний тооны нэрийг харьцуулан үзсэний дүнд эдгээр хэлнүүдийн тооны нэрийн дийлэнх хувь буюу 70 гаруй хувь нь гарал, бүтцийн холбоо сүлбээтэй, хөгжил хувьслын ойр дөхүү зам мөрийг туулжээ хэмээн дүгнэж болохоор байна.

Abstract

About cardinal numbers of Manchu and Mongolian

The comparative study of numeral is one of the most important work to investigate the relationship of the Altaic languages. Thus, I pretend to focus my attention on a comparative study of the Mongolian-Manchu cardinal numerals.

The cardinal numeral's main structure is:

- a. stem+suffix "ban" (or it's versions)
- b. stem+suffix "r"+suffix "ban" (or it's versions)

I think, an earlier original form of cardinal numerals can be reconstructed based on this general structure. For example, *ni-r-ben > mo. ni-gen, ma. emu.

In my view, Manchu use Tibetan words for the numerals above 10000 which is definitely tranferred by Mongolian and this is demonstrate that Manchu-Tungus further Jurchen was under the deapest influence of Mongolian culture.

Scholars who stand on the field of Non-Altaic theory use the numeral correnpondence of these languages to express serious doubts concerning the validity of the Altaic theory. As a result of my work, I concluded the greater part of Mongolian-Manchu numerals (more than 70 percent) have a genetic relationship, common structures and their evolution path is same in basically. And some of them such as Jurchen's numeral "11 to 19" is cause of Altaic language correspondence.